Funded by
European Union
Civil Protection
and Humanitarian Aid

PEOPLE IN NEED
CZECH REPUBLIC

MERCY CORPS

FEG
THE FOOD ECONOMY GROUP

Монгол улсын өрхийн эдийн засгийн шинжилгээ (HEA) Сүхбаатар аймгийн тал хээр, Архангай аймгийн өндөр уулын мал аж ахуйн бүс болон Монгол улсын 2017-2018 он, 2018-2019 онуудын нөхцөл байдлын дүн шинжилгээ

Улаанбаатар, 2018

Funded by
European Union
Civil Protection
and Humanitarian Aid

Монгол улсын өрхийн эдийн засгийн шинжилгээ (HEA) Сүхбаатар аймгийн тал хээр, Архангай аймгийн өндөр уулын мал аж ахуйн бүс болон Монгол улсын 2017-2018 он, 2018-2019 онуудын нөхцөл байдлын дүн шинжилгээ

Улаанбаатар, 2018

Энэхүү судалгааг Европын Холбооны Иргэний хамгаалал, хүмүүнлэгийн туслалцааны албанаас (ECHO) "Гамшгийг даван туулахад технологийн болон уламжлалт аргыг ашиглах нь" (LTT4R) төслийн хүрээнд санхүүжүүлсэн болно. Төслийг Пипл ин Нийд олон улсын ТББ болон Мерси Кор байгууллагын хамтарсан консорциум хэрэгжүүлж буй юм. Энэхүү ажлын хүрээнд хийгдсэн судалгааг Пипл ин Нийд хийж гүйцэтгэлээ.

Тайланг Хүнсний эдийн засгийн группийн (FEG) Александра Кинг бэлтгэсэн. Энэхүү тайланд дурдагдсан судалгаа, шинжилгээг Хүнсний эдийн засгийн групп удирдан хийж, Александра Кинг, Риа Льюс нар шаардлагатай мэдээллийг бэлтгэн гаргасан. Үр дүнгийн шинжилгээг мөн Александра Кинг гүйцэтгэсэн.

Судалгааны үйл ажиллагааг гардан гүйцэтгэсэн багийн гишүүдэд онцгойлон талархал илэрхийлж байна. Багийн бүрэлдэхүүнд доор дурдсан гишүүд ажилласан:

Баасанжавын Ганчимэг (Пипл ин Нийд)
Өлгийтийн Эрдэнэбилэг (Мерси Кор)
Пүрэвийн Түмэнбаяр
Гэндэндоржийн Дэлгэрмаа
Одончимэгийн Болормаа

Дээрх судалгааны багийн гишүүдээс гадна Батсүхийн Билгүүн (Мерси Кор) үр дүнгийн шинжилгээнд оролцсон.

Тайланд багтсан бүхий фото зургуудыг Лорел Хансон, Ганчимэг Баасанхүү, Оргил Мөнхбаяр (Пипл ин Нийд) болон Режис Дефурно нар авсан болно. Режис Дефурно нь Монголын хөдөө орон нутгийн шилжилтийн тухай баримтат гэрэл зураг авч байгаа бөгөөд тус зургууд нь "өвлийн улиралд эрвээхэй шиг" төслийн нэг хэсэг юм.

Тус тайланг Европын Холбооны Иргэний хамгаалал, хүмүүнлэгийн туслалцааны алба (ECHO) санхүүжүүлсэн бөгөөд баримт бичигт дурдагдсан үзэл бодол нь Европын Комисс болон Европын Холбооны албан ёсны үзэл бодлыг тусгаагүй болно.

Funded by
European Union
Civil Protection
and Humanitarian Aid

Агуулга

Хүснэгтүүдийн жагсаалт 7
Зургуудын жагсаалт 7
Тойм 8
Танилцуулга 13
1. Өрхийн эдийн засгийн шинжилгээний суурь мэдээлэл: Архангай аймгийн өндөр уулын, мал аж ахуйн амьжиргааны бүс 15
Амьжиргааны бүсийн танилцуулга 15
Зах зээл, зах зээлийн хүртээмж 16
Улирлын хамаарал, хугацаа, тулгарах аюул гамшиг 17
Хөрөнгийн задаргаа, үр ашигтай хөрөнгө 20
Хоол хүнсний эх үүсвэр 22
Мөнгөн орлогын эх үүсвэр 24
Зарцуулалт 26
Мал сүргийн шилжилт нүүдэл 28
Хариу арга хэмжээний стратегиуд 28
Гол үзүүлэлтүүд 29
Хөтөлбөрийн үзүүлэх нөлөөлөл 29
2. Өрхийн эдийн засгийн шинжилгээний суурь мэдээлэл: Сүхбаатар аймгийн тал хээрийн бүсийн, мал аж ахуйн амьжиргааны бүс 32
Амьжиргааны бүсийн танилцуулга 32
Зах зээл, зах зээлийн хүртээмж 34
Улирлын хамаарал, хугацаа, тулгарах аюул гамшиг 35
Эд хөрөнгийн задаргаа, үр шимтэй эд хөрөнгө 37
Хоол хүнсний эх үүсвэрүүд 39
Мөнгөн орлогын эх үүсвэрүүд 40
Зардал 42
Мал сүргийн шилжилт нүүдэл 44
Хариу арга хэмжээний стратеги 44
Гол үзүүлэлтүүд 45
Хөтөлбөрийн үзүүлэх нөлөөлөл 46
3.2017–2018 болон 2018–2019 онуудын Монгол улсын нөхцөл байдлын дүн шинжилгээ: Хоёр аймгийн орон нутгийн амьжиргааны бүс 48
Өрхийн эдийн засгийн үнэлгээний арга зүй болон Монгол улсын амьжиргааны суурь мэдээлэл 48
Амьжиргааны суурь мэдээлэл (Нөхцөл байдал) 49
Мониторингийн мэдээллээс асуудлын тодорхойлолтыг боловсруулах нь (Өөрчлөлтүүд) 52
Таамаг нөхцөл байдлын дүн шинжилгээ (Үр дүнгийн шинжилгээ) 53
НӨХЦӨЛ БАЙДАЛ 55
2017- 2018 оны нөхцөл байдал 56
2018- 2019 оны нөхцөл байдал 58
Таамаглан гаргасан хүнсний баталгаат байдлын хэтийн төлөв 59
2017- 2018 оныг хамрах үр дүн 59
2018- 2019 оныг хамрах үр дүн 61
Хавсралт 1: Улирлын хуанли 63

Хүснэгт, зургуудын жагсаалт

Хүснэгтүүдийн жагсаалт

Хүснэгт 1: Бүс 01 Өрхийн эдийн засгийн шинжилгээний суурь мэдээллийн тойм 10
Хүснэгт 2: Бүс 02 Өрхийн эдийн засгийн шинжилгээний суурь мэдээллийн тойм 11
Хүснэгт 3: Бүс 01 Баялгийн бүлгүүдийн шинж чанарууд 20
Хүснэгт 4: Бүс 01 Өрхийн орлого 24
Хүснэгт 5: Бүс 01 Гол үзүүлэлтүүд 29
Хүснэгт 6: Бүс 02 Баялгийн бүлгүүдийн шинж чанарууд 37
Хүснэгт 7: Бүс 02 Өрхийн орлого 38
Хүснэгт 8: Бүс 02 Гол үзүүлэлтүүд 45
Хүснэгт 9: Бүс 01 Өрхийн эдийн засгийн шинжилгээний суурь мэдээллийн тойм 50
Хүснэгт 10: Бүс 02 Өрхийн эдийн засгийн шинжилгээний суурь мэдээллийн тойм 51
Хүснэгт 11: Бүс 01 болон 02-ын голлох үзүүлэлтүүд 52
Хүснэгт 12: Өрхийн эдийн засгийн шинжилгээ, хамрах хугацаа 55
Хүснэгт 13: Судалгаанд хамрагдсан жилүүдийн улирлын хуанли (Хавсралт 1 дээр мөн оруулсан) 56
Хүснэгт 14: Үнийн нөхцөл байдал, инфляц 56-57
Хүснэгт 15: Мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөхцөл байдал 57-58
Хүснэгт 16: Хүнс, орлогын бусад эх үүсвэрийн талаарх таамаг нөхцөл байдал (тоо хэмжээний асуудал) 58

Зургуудын жагсаалт

Зураг 1: Бүс 01 Улирлын хуанли 18
Зураг 2: Бүс 01 Хоол хүнсний эх үүсвэр 22
Зураг 3: Бүс 01 Мөнгөн орлогын эх үүсвэр 24
Зураг 4: Бүс 01 Орлогын эх үүсвэр, банкны зээлээс бусад 25
Зураг 5: Бүс 01 Зардлын хэв шинжүүд 26
Зураг 6: Бүс 01 Зардлын хэв шинж, зээлийн үндсэн төлбөр оруулсан 27
Зураг 7: Бүс 02 Улирлын хуанли 36
Зураг 8: Бүс 02 Хүнсний эх үүсвэрүүд 39
Зураг 9: Бүс 02 Мөнгөн орлогын эх үүсвэрүүд 40
Зураг 10: Бүс 02 Мөнгөн орлогын эх үүсвэрүүд-банкны зээлийн эргэн төлөлтийг хассан 41
Зураг 11: Бүс 02 Зардлын хэв шинж 42
Зураг 12: Бүс 02 Зардлын хэв шинж, цэвэр зээл эргэн төлөлтийн хамтаар 43
Зураг 13: Өрхийн эдийн засгийн үнэлгээний арга зүй 48
Зураг 14: Өрхийн эдийн засгийн шинжилгээний хүрээлэл-хялбаршуулсан зураглал 54
Зураг 15: Бүс 01 Үр дүнгийн шинжилгээ, 2017-18 59
Зураг 16: Бүс 02 Үр дүнгийн шинжилгээ, 2017-2018 60
Зураг 17: Бүс 01 2018-2019 оны Үр дүнгийн шинжилгээ 61
Зураг 18: Бүс 02 2018-2019 оны Үр дүнгийн шинжилгээ 62

Тойм

Энэхүү тайланд Монгол улсын амьжиргааны хоёр өөр бүсэд 2017 оны 10-11 дүгээр сард хийсэн Өрхийн эдийн засгийн шинжилгээний (Household economy analysis) суурь мэдээлэл, 2018 оны 1 дүгээр сард хийсэн Өрхийн эдийн засгийн шинжилгээний хүрээнд хамаарах баримт бичгийн судалгааны явцад хийгдсэн Үр дүнгийн шинжилгээнээс (Outcome analysis) гарсан үр дүнг танилцуулж байна.Пипл Ин Нийд (People in Need буюу цаашид ПИН гэх) байгууллагын гүйцэтгэсэн энэхүү судалгааны ажил нь ПИН болон Мерси Корын үйл ажиллагаа явуулж буй аймгуудад амьжиргааны хувьд өөр өөр бүлгүүдийн амьжиргаа, амьдрах арга зам, мөн тэдний улирлын чанартай амьжиргааны стратегийн талаар гүнзгийн ойлголттой болох зорилготой юм.

Тус тайлан нь гурван хэсгээс бүрдэнэ. Эхний хоёр хэсэгт амьжиргааны хоёр бүсийн Өрхийн эдийн засгийн шинжилгээний үндсэн үр дүнг харуулсан бөгөөд доорх хоёр хүснэгтэд энэхүү мэдээллийг тоймлон харууллаа:

Бүс 01: Архангай аймгийн өндөр уулын мал аж ахуйн амьжиргааны бүс		
Мал	Сарлаг Адуу Ямаа Хонь Ноолуур Ноос Сарлагийн сүү Мах Мах борлуулсны орлого Мал аж ахуйн салбарт ажил эрхлэх	*Архангай аймгийн өндөр уулын, мал аж ахуйн амьжиргааны бүс нь* үндсэндээ Архангай аймгийн баруун хэсгийг хамран оршдог. Тухайн бүс нь уур амьсгалын хувьд Баруун Монгол болон Хангайн нурууг дагасан эрс тэс уур амьсгалтай юм. Тухайн бүс нь мөн хагас цөлжсөн, ойт-хээрийн бүс, дов толгодоор бүрхэгдсэн байдаг. Амьжиргааны энэхүү бүс нь эдийн засгийн хувьд мал аж ахуй, мал аж ахуйн бүтээгдэхүүнд суурилсан бөгөөд сарлаг, адуу, хонь, ямаа голлон өсгөдөг. Мөн орон нутгийн гол эдийн засгийн суурь нь амьд малын арилжаа, малын гаралтай бүтээгдэхүүн болох сүү, ааруул, шар тос, тараг, айраг, ноос, ноолуур зэрэг бүтээгдэхүүн юм. Амьд малын арижааны хувьд сарлаг, адуу өндөр үнэлгээтэй байсан бол мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнээс ямааны ноолуур нь хамгийн өндөр үнэлэгддэг байна. Хонины ноосыг дотоодын боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн тохиолдолд малчид ноосны нөхөн олговор авдаг ба энэ нь өөр бусад орлого олохуйц бүтээгдэхүүн үйлдвэрлэх сэдлийгбууруулж байна.
Орлогын бусад эх үүсвэрүүд	Төрөөс олгох нийгмийн халамж Зээл	Бүх бүлгийн хувьд өрхийн орлого нь мал аж ахуй болон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний борлуулалтаас бүрэн хамаардаг бөгөөд хамгийн багадаа нийт орлогынх нь гуравны нэг хувь байдаг байна. Амьжиргааны түвшин доогуур бүлэг ньайлын мал хариулах, хонь ноослох, байгалаас жимс самар түүж зарж борлуулах, түлшний мод бэлтгэж зарах зэргээр нэмэлт орлого олдог байна.

Хүснэгт 1: Бүс 01 Өрхийн эдийн засгийн шинжилгээний үндсэн мэдээллийн тойм

Бүс 02: Сүхбаатар аймгийн тал хээрийн мал аж ахуйн амьжиргааны бүс		
Мал	Үхэр Адуу Ямаа Хонь Ноолуур Ноос Үхрийн сүү Мах Мал аж ахуйн салбарт ажил эрхлэх	*Сүхбаатар аймгийн тал хээрийн, мал аж ахуйн амьжиргааны бүс* нь Монгол орны зүүн хэсгийн Сүхбаатар аймгийг хамран оршино. Тухайн бүс нь хагас цөлөрхөг бүс бөгөөд, цаг уурын хувьд эрс тэс, хуурай, өргөн уудам тэгш, өвст тал бүхий онцлогтой. Амьжиргааны энэ бүсийн хүн ам нь үндсэндээ нүүдэлч малчдаас бүрддэг. Бүсийн үндсэн амьжиргаа мал аж ахуйд суурилах ба хонь, ямаа, үхэр, адуу, цөөн тооны тэмээ өсгөн үржүүлж байна. Тухайн бүс нь адуу голлон өсгөдөг, хурдан удмын адуутай гэж тооцогддог тул Монгол орны бүхий л нутгаас хүмүүс ирж хурдны морь худалдан авдаг. Мал аж ахуйн салбар нь бэлчээрийн маллагаатай, нийтийн эзэмшлийн бэлчээрт бүтэн жилийн туршид малаа бэлчээдэг.
Орлогын бусад эх үүсвэрүүд	Төрөөс олгох нийгмийн халамж Зээл	Бүх төрлийн малыг зарж борлуулдаг. Мал аж ахуйн гол бүтээгдэхүүн нь Баяндэлгэрийн улаан ямааны сайн чанарын ноолуур. Ноос болон арьс шир нь мал аж ахуйн хоёрдогч бүтээгдэхүүн болно. Үхрийн сүү, сүүн бүтэгдэхүүнийг өрхийн хэрэгцээнд ашиглахын зэрэгцээ мөн зарж борлуулдаг. Үнээнээс бусад төрлийн малыг саадаггүй. Мал тарга хүч сайн авсан, эрэлт өндөр зун, намрын улиралд амьд мал голлон борлуулдаг бөгөөд энэ үеэр ч малчдын бэлэн мөнгөний хэрэгцээ өндөр байдаг ажээ. 3-4 дүгээр сард ноолуур, 6-8 дугаар саруудад ноосоо борлуулдаг. Өвлийн улиралд мал аж ахуйгаас олох орлого буурч, маш бага хэмжээнд хүрдэг. Амьжиргаа доогуур өрхүүд мал ихтэй айлуудын хонь ноослох, мал маллах ажил хийх зэргээр орлого олдог байна.

Хүснэгт 2: Бүс 02 Өрхийн эдийн засгийн шинжилгээний үндсэн мэдээллийн тойм

Энэхүү тайлангийн гуравдугаар хэсэгт үр дүнгийн шинжилгээний үр дүнг тусгасан. Үр дүнгийн шинжилгээний сургалт, шинжилгээний хэсгийг хамарсан сургалтын үеэр шинжилгээний үндсэн нөхцөл байдлыг (scenario) тодорхойлон гаргасан. Үүний гол зорилт нь хоёр бүсийн Өрхийн эдийн засгийн үр дүнгийн шинжилгээг ашиглан 2017-2018 болон 2018-2019 оны өрхийн эдийн засгийн нөхцөл байдлыг таамаглах, нэн тэргүүний хэрэгцээг тогтоох, тогтвортой амьжиргааны урт хугацааны хөгжилд шаардлагатай бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах явдал юм.

Энэхүү шинжилгээ, судалгаанд 2017 оны 6 дугаар сараас 2018 оны 5 дугаар сар (энэ жил) болон 2018 оны 6 дугаар сараас 2019 оны 5 дугаар сарыг (дараа жил) хамруулан судалсан. Мал аж ахуйн үйлдвэрлэл, бараа бүтээгдэхүүний үнийн албан ёсны статистик мэдээллийг ашиглан тухайн жилд ямар асуудал тулгарч буйг тодорхойлсон. Нөхцөл байдлын элемент нэг бүрийг тайлан дээр тодорхой тайлбарласан ба цаашид нэмэлт мэдээлэл цуглуулан судалсны үндсэн дээр нөхцөл байдлыг эргэн харж, мониторинг хийж байх боломжтой юм.

Шинжилгээнд хамруулсан хугацаанд иргэдийн амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж буй гол хүчин зүйл нь зун тохиох ган, өвлийн их цас, хүйтэн цаг ууртай хавсран үүсэж, мал сүрэг олон тоогоор хорогдоход хүргэх зуд юм. Сүхбаатар аймгийн хувьд 2017 онд зудын байдал үүсэж, улмаар хорио цээр тогтоон, мал, амьтны худалдаанд хориг тавихад хүргэсэн малын шүлхий өвчинтэй хавсран ноцтой сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

Шинжилгээний хүрээнд хоёр тусдаа хугацааг хамруулсан ба үүнд:
1) зун ган болж, өвөл ихээр хүйтэрсэн энэ жил (2017 оны 6 дугаар сараас 2018 оны 5 дугаар сар), болон 2) өмнөх жилийн малын хорогдлын нөлөө мэдрэгдэж эхлэх дараа жил (2018 оны 6 дугаар сараас 2019 оны 5 дугаар сар) багтана.

Энэ онд тохиолдож болох (тайлан дээр дурдсан) зүйлсийн таамаг дээр суурилан нэгдүгээр бүс буюу Архангай аймгийн өрхүүд нь 2017-2018 онуудад амьжиргаа баталгаажуулах/хамгаалах арга хэмжээ авах хэрэгцээ, амьжиргааны хомсдолтой тулгарах магадлалгүй байна. Хоёрдугаар бүс буюу Сүхбаатар аймгийн нэн ядуу өрхүүд нь амьжиргаа хамгаалах арга хэмжээ авч болох босго түвшинд байна (босгоос доогуур). Энэ нөхцөл байдал нь амьд малын худалдаа буурах (2017 онд тавигдсан хорио цээрийн дэглэмээс шалтгаалан), 2018 оны ноолуурын үнээс хамааралтай, эдгээрт ихээхэн эмзэг байна. Үүнийг харгалзан хэрэгжүүлж болох арга хэмжээний хүрээнд Сүхбаатар аймгийн энэ бүлэгт 2018 оны 5 дугаар сараас өмнө зарим тусламж дэмжлэг хүргэх ажил багтаж болно.

Судалгааны хүрээнд дэвшүүлсэн таамаг дээр үндэслэн үзвэл хоёр амьжиргааны бүсийн өрхүүдийн хувьд 2018-2019 онуудад нь амьжиргаа баталгаажуулах арга хэмжээний хэрэгцээ эсвэл амьжиргааны хомсдолтой нүүр тулах магадлалгүй юм. Харин 2017-18 оныг хамруулсан шинжилгээний үр дүн нь амьд малын борлуулалт буурах (хорио цээрийн дэглэмээс шалтгаалан), ноолуурын үнэ доогуур байх таамагт үндэслэн амьжиргааны нөхцөл эмзэг байж болох дүр зураг харагдаж байна. 2018-2019 оны таамгийн дагуу тухайн бүсүүдийн нэн ядуу өрхүүд амьжиргаа хамгаалах/баталгаат босгонд маш ойр хэмжээнд байх тул нөхцөл байдалд байнгын мониторинг хийж байх шаардлагатай юм. Нэмэлт мэдээлэл цуглуулсан тохиолдолд шинжилгээнд ашигласан аль ч таамгийг эргэн харж, өөрчлөх боломжтой.

ТАНИЛЦУУЛГА

Энэхүү тайлан нь Монгол улсын амьжиргааны хоёр бүс дээр 2017 оны 10-11 дүгээр саруудад хийгдсэн Өрхийн эдийн засгийн шинжилгээний хүрээнд цуглуулсан (Household economy analysis) суурь мэдээлэл болон 2018 оны 1 дүгээр сард хийгдсэн Өрхийн эдийн засгийн шинжилгээний баримт бичгийн судалгааны хүрээнд хийгдсэн Үр дүнгийн шинжилгээнээс (Outcome analysis) гарсан үр дүнг танилцуулж байна. Суурь шинжилгээний үйл ажиллагааны гол зорилго нь ПИН болон Мерси Корын үйл ажиллагаа явуулж буй нутгийн ард иргэдийн амьжиргаа, арга хэрэгсэл болон амьжиргааны стратегийн улирлын ялгаатай байдлын тухай шинэлэг, гүнзгийрүүлсэн ойлголтыг бүрдүүлэх явдал байв. Үр дүнгийн шинжилгээ нь 2017-2018 болон 2018-2019 онуудын өрхийн амьжиргаа, эдийн засгийн нөхцөл байдлыг таамаглан гаргах зорилтуудын хүрээнд хийгдсэн. Улмаар тус шинжилгээний хүрээнд цуглуулсан мэдээллийг Сүхбаатар, Архангай аймгууд дахь зудад нэрвэгдсэн ядуу өрхүүдийн нөхцөл байдлыг сайжруулах зорилго бүхий хүнсний баталгаат байдал/амьжиргааг дэмжих үйл ажиллагааг төлөвлөн явуулахад ашиглах юм.

Энэхүү тайлан нь гурван хэсгээс бүрдэнэ. Эхний хоёр хэсэг нь амьжиргааны хоёр бүсийн Өрхийн эдийн засгийн шинжилгээний суурь үр дүнг тусгасан. Гурав дахь хэсэгт үр дүнгийн шинжилгээнээс гарсан дүнг тусгасан.

Энэхүү судалгаа нь Монгол улсын малчин иргэдийн эмзэг байдал, малчин өрхийн эдийн засгийн тухай бүрэн ойлголт авахын тулд ПИН байгууллагын зүгээс хийж гүйцэтгэж буй үйл ажиллагааг ахисан түвшинд гаргаж буй юм. Үүний хүрээнд Asia-Onlus[1] байгууллагын санхүүжилтээр 2017 онд хийсэн "Зудын үеийн эмзэг бүлгийн өрхүүдийн өр,түүний эмзэг байдалд хамаарах хамаарал"-ын судалгаа болон 2016-2017 онуудад ПИН байгууллагын зүгээс зудын үеийн яаралтай хариу арга хэмжээний хүрээнд хийгдсэн "Тусламж түгээлтийн дараах мониторинг" зэрэг судалгаа зэрэг нь *өрхийн эдийн засгийн тухай* бүтэн бүлэг[2] агуулсан байдаг.

а Дараах хаягаар үзнэ үү: https://www.clovekvtisni.cz/media/publications/720/file/1485342111-indebtedness-dzud.pdf

Дараах хаягаар үзнэ үү:
https://reliefweb.int/sites/reliefweb.int/files/resources/People%20in%20Need%20basic%20Findings%20from%20Post-Distribution%20Monitoring_Dzud%20Emergency%20Response%202017.pdf

1. Өрхийн эдийн засгийн шинжилгээний суурь мэдээлэл: Архангай аймгийн өндөр уулын, мал аж ахуйн амьжиргааны бүс

2017 оны 12 дугаар сар

Амьжиргааны бүсийн танилцуулга

Архангай аймгийн өндөр уулын, мал аж ахуйн амьжиргааны бүс[3] нь үндсэндээ Архангай аймгийн баруун хэсгийг хамран оршдог. Тухайн бүс нь Баруун Монгол болон Хангайн нурууг даган байрших туйлын дэд бүсийн уур амьсгалтай, мөн хагас цөлжсөн, ойт-хээрийн бүс, дов толгодоор бүрхэгдсэн.

Усны нөөц бүхий хэд хэдэн газар нутагт томоохон голууд болох Чулуут, Хануй, Тамирын голын сав газар багтах ба аймгийн хойд хэсгээс эхлэн урагш чиглэлийн урсгалтай. Цаг агаарын хувьд зуны улиралд дээд тал нь +38С хэм, өвлийн улирал -40С хэм хүртэл хүйтэрдэг. Аймгийн хүн амын нягтаршил бага, нэг хавтгай дөрвөлжин километр газарт 1.6 хүн ноогдоно. Аймгийн төв Цэцэрлэг хот нь Улаанбаатар хотоос 460 километр зайтай. Зам тээврийн сүлжээний хувьд бусад орон нутагтай ижил, алслагдсан байдалтай. Аймгийн төвийг Улаанбаатар хот, цаашлаад Хятадтай болон баруун аймгуудтай холбосон хатуу хучилттай зам дайрч өнгөрдөг.

Энэ бүсийн хүн ам нь үндсэндээ нүүдэлч малчдаас бүрдэнэ. Суурин газрын оршин суугчид, сумын төвийн байнгын оршин суугчдыг суурь судалгаанд хамруулаагүй. Монгол улсын хэмжээнд одоогоор албан ёсны амьжиргааны бүсчлэл гараагүй байна. *Өндөр уулын амьжиргааны бүс* нь Архангай аймагт буй хоёр (хамгийн багаар тооцоход) бүсийн нэг бөгөөд зөвхөн аймгийн хилээр хязгаарлагдахгүй байж болно. Бүсийн нөхцөл байдлыг тодорхойлох орон нутгийн судалгааг Архангай аймгийн Ихтамир, Чулуут, Тариат, Хангай, Цахир, Өндөр-Улаан, Булган, Цэнхэр сумдад хийж гүйцэтгэсэн.

Амьжиргааны энэ бүсийн эдийн засаг нь үндсэндээ мал аж ахуй, мал аж ахуйн үйлдвэрлэл дээр суурилдаг. Тус бүсэд сарлаг, адуу, хонь, ямаа голлон өсгөж байна. Амьд мал, малын гаралтай бүтээгдэхүүн болох сүү, ааруул, шар тос, тараг, айраг, ноос, ноолуур зэрэг бүтээгдэхүүн эдийн засгийн үндэс болж байна. Амьд малын зах зээл дээр сарлаг, адуу хамгийн өндөр үнэлгээтэй байдаг бол мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнээс ноолуур нь хамгийн өндөр үнээр борлуулагддаг ба судалгаа хийсэн жилийн хувьд 1 кг ноолуур ойролцоогоор 55,000 төгрөг үнэтэй (ойролцоогоор 28[4] ам.доллар) байв. Малчдын хувьд дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлсэн ноосондоо Засгийн газраас татаас авдгаас үүдэн бусад төрлийн үр ашигтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх сэдлийг хааж байна. Судалгаанд хамрагдсан бүлгүүдийн гуравны нэг нь эдгээр мал, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний эх үүсвэрээс хамааралтай.

3 Энэхүү нөхцөл байдлыг тодорхойлох хээрийн судалгааны үйл ажиллагааг 2017 оны 11 дүгээр сард хийсэн. Тус тодорхойлолт дээр багтсан мэдээлэл нь 2015 оны 6 дугаар сараас 2016 оны 5 дугаар сарыг хүртэлх хэрэглээний жил болох тухайн жилд хамааралтай мэдээлэл юм. Эдийн засагт ямар нэгэн суурь эсвэл гэнэтийн өөрчлөлт гарахгүй хэмээн үзвэл энэхүү тодорхойлолтод багтсан мэдээлэл нь ойролцоогоор 5- 10 жилийн хугацаанд хүчинтэй байж болно (жишээ нь 2022- 2027 оныг хүртэл). Баримт бичигт дурдагдсан бүхий л үнэ нь тухайн хамаарах жилийнх болно.

4 Хамаарах жилд валютын ханш нь ойролцоогоор 1 ам.доллар 2,000 төгрөгтэй тэнцэж байсан.

Ядуу, орлого багатай өрхүүд нь дутагдаж буй орлогоо айлын мал маллах (туслах малчин), хонь хяргах, мод түлээ, сонгино, самар жимс зэргийг байгалаас түүж зарж борлуулах зэргээр нэмэлт орлого олдог байна.

Амьжиргааны энэхүү бүсийн байгалийн гол нөөц нь мал бөгөөд үүний зэрэгцээ жимс, самар, зэрлэг сонгино болон ан агнуурын (хууль бус) бусад нөөцтэй. Өндөр-Улаан сумыг (тосгон) үл тооцон судлахад ихэнх малчид нь байгалийн жимс жимсгэнэ, сонгино, самар түүж бага хэмжээгээр борлуулах замаар нэмэлт орлого олж байна. Мөн зарим хүмүүс намрын улиралд зэргэлдээ аймаг, сум руу явж байгалаас жимс, сонгино, самар түүн борлуулдаг. Өвлийн улиралд Говийн малчид Архангай аймагт малтайгаа оторлон ирдэг.

Зах зээл, зах зээлийн хүртээмж

Архангай аймгийн өндөр уулын, мал аж ахуйн амьжиргааны бүсийн зах зээлийн хүртээмж нь үндсэндээ алслагдсан, бусад хөдөө орон нутагтай ижил нөхцөлтэй. Хатуу хучилттай замын нөхцөл нь ерөнхийдөө сайн. Гол замаас салаалсан шороон замууд Архангай аймгийн бүхий л сумдад хүргэнэ. Гэвч тухайн замын нөхцөлөөс үүдэн бороо, цастай үед зорчиход хүндрэлтэй. Ихэнх өрхүүд ойролцоо зах зээлд мотоциклоор эсвэл машинаар явж хүрдэг. Хэрэгцээт зүйлсээ худалдан авахдаа сарын хэрэглээний хэмжээгээр нь сумын захаас худалдан авдаг. Бороо их орсон үед голууд үерлэн, зах зээлдээ хүрэхэд хүндрэлтэй болдог байна. Амьжиргаа сайтай чинээлэг болон дунд орлоготой өрхүүдийн ихэнх нь машинтай тул зах зээлд хүрэхэд тэдэнд харьцангуй хялбар байх ба мотоциклоос өөр унаагүй ядуу, нэн ядуу өрхүүд хязгаарлагдмал тооны бараа бүтээгдэхүүн нэг удаад худалдан авахаас өөр сонголт байхгүй. Бороо хур ихтэй улиралд гол үерлэх (6-9 дүгээр саруудад) эсвэл цас орсны улмаас зам хаагдах (12-2 дугаар сар) тохиолдолд эдгээр өрхүүдэд хүрч очих нь хүндрэлтэй байдаг. Тиймээс зарим өрх өвөл эхлэхээс өмнө (11-12 сард) хүнсний зүйлс болон бусад шаардлагатай зүйлсээ худалдан авч нөөцөлдөг.

Тухайн бүсийн малчин өрхүүдийн үндсэн, хамгийн үнэ цэнэтэй бүтээгдэхүүн нь мал бөгөөд түүнийгээ бүх төрөл дээр өсгөн үржүүлж, зарж борлуулдаг байна. Эдгээр нь сарлаг, ямаа, хонь болон бусад мал багтана. Худалдааны гол маршрут нь тухайн борлуулж буй бүтээгдэхүүнээс (мал, бусад бүтээгдэхүүн) хамаардаг. Ихэнх худалдаа нь ченжүүдээр дамжин хийгддэг. Амьд малын худалдааны хувьд малчид өөрсдөө аймаг, сумдээрээ авчран ченжүүдэд худалдаалдаг байна. Борлуулсан бүх мал, малын гаралтай бүтээгдэхүүн Улаанбаатар хотод хүргэгдэж борлуулагдах бөгөөд тус зах зээлийн эрэлт нь аймаг дээрх малын үнийг тогтоодог. Ноос хяргах, ямаа самнах ажлыг малчид өөрсдөө хийж, бүтээгдэхүүнээ сумын ченжүүдэд нийлүүлэн, улмаар тухайн ченжүүд нь аймагт борлуулж, цааш Улаанбаатар хотод авчран зардаг. Зарим тохиолдолд сумын ченжээс шууд Улаанбаатар хотын зах зээлд зарим бүтээгдэхүүн нийлүүлэгдэнэ. Энэ нь тухайн сумын ченжийн санхүүгийн боломжоос ихээхэн хамаардаг. Архангайн сарлагийн хөөврийг малчид хоршоонд нийлүүлэн, тэндээс боловсруулах үйлдвэрүүдэд хүргэгдэн, улмаар экспортын зах зээлд нийлүүлэгдэж байна.

Амьжиргааны энэ бүсийн хүнсний ногооны үйлдвэрлэл хязгаарлагдмал. Цаг уур хүйтэн сэрүүн учраас ногоо тарьж ургуулах хүндрэлтэй. Хамгийн их тариалдаг хүнсний ногоо нь төмс бөгөөд орон нутгийн иргэдийн хэрэгцээнд нийлүүлдэг. Иргэдийн хэрэглэж буй хүнсний ногооны ихэнхийг импортоор авдаг бөгөөд аймгийн төв дээр зарагдаж буй ногооны дийлэнх нь Хятад, Оросоос импортлон авчирсан хүнсний ногоо байна.

Хөдөө орон нутагт олдож байгаа ур чадвар бага шаардах ажлын байрны дийлэнх (90%) нь түр ажлын байр байдаг байна. Дундаж болон чинээлэг өрхүүд нь мал маллах, хонь хяргах, ямаа самнах зэрэг ажилд түр хугацаагаар бусдыг хөлслөн ажиллуулдаг байна. Эмзэг бүлгийн зарим малчид "туслах малчнаар" ажиллаж бэлэн мөнгө эсвэл бусад бараа бүтээгдэхүүнээр (жишээ нь мал, малын гаралтай бүтээгдэхүүнээр) цалинждаг.

Улирлын нөлөө, тулгарах байгалийн аюул гамшиг

Энэхүү судалгааны суурь үнэлгээ нь "суурь жил" хэмээн нэрлэгдэх өвөрмөц онцлог бүхий хугацааг (бусад жилүүдийн нөхцөл байдлыг харьцуулах үзэх суурь) хамран хийгдсэн. *Архангай аймгийн өндөр уулын, мал аж ахуйн амьжиргааны бүсэд* энэхүү суурь он нь 2015 оны 6 дугаар сараас 2016 оны 5 дугаар сарыг хүртэлх хугацааг хамарсан. Малчдын бүлэг, хоршооны ахлагчдаас судалгаа авахдаа тухайн орон нутгийн сүүлийн таван жилийг улирлын хувьд ангилаад тухайн жилийг хамгийн тааламжтай байснаар нь 1-5 хүртэл оноогоор (1 хамгийн тааламжгүй, 5 хамгийн таатай) дүгнэн гаргуулсан. Бүсийн ихэнх хэсгийн хувьд тухайн сонгон авсан суурь хугацаа нь тааламжтай байдлын хувьд дундаж буюу 3 гэсэн оноогоор үнэлэгдсэн. Гэхдээ зарим сумдад 2015-2016 оны өвөл нь зуд болсоны улмаас дараагийн жил нь мал аж ахуйгаас олох орлого, үйлдвэрлэл буурчээ. Судалгаанд хамрагчдагчын ихэнх нь мэдээлснээр зудын давтамж өмнөх жилүүдийнхээс илүү нэмэгдэж байна гэсэн байна. Судалгаа хийсэн жилийн өмнөх жилд нь байгалийн нөхцөл байдал нь дундаж эсвэл дунджаас дээгүүр хэмжээнд байжээ.

Бүсийн оршин суугчид тулгарч буй гол аюулыг буурах дараалаар нь нэрлэхэд нэгдүгээрт зуд, дараа нь ган болон бэлчээрийн доройтол оржээ. Мөн малчин өрхүүдийн хувьд бас ойн түймэр тодорхой аюул учруулдаг байна. Амьжиргааны бүсийн мал сүрэгт сөргөөр нөлөөлж буй олон тооны малын өвчин, шимэгч буйн дотор үхрийн цусан халдвар, боом, селенийн дутагдал, шимэгч хорхой зэрэг нь түгээмэл байдаг ажээ. Энэ төрлийн өвчнөөр үндсэндээ сарлаг, ямаа, хонь түлхүү өвчилдөг байна. Вакцинжуулалт, угаалга, туулга нь түгээмэл хийгддэг эмчилгээ бол боом, цусан хавдрын вакциныг төрийн зүгээс үнэ төлбөргүй хийдэг. Малын өвчин нь жилийн тодорхой улиралд тогтмол дэгддэггүй ч малчдын хувьд ихээхэн архагшсан асуудал болжээ.

Лавлах хамаарах он												
	Зун			Намар			Өвөл			Хавар		
	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар
Мал												
Бороо хуртай улирал												
Цас												
Салхи												
Сарлаг												
Орооны цаг, үржил хээлтүүлэг												
Мал төллөлт												
Борлуулалт												
Сүүний үйлдвэрлэл												
Хонь, ямаа												
Орооны цаг, үржил хээлтүүлэг												
Мал төллөлт												
Борлуулалт												
Сүүний үйлдвэрлэл												
Отор нүүдэл												
Орлого төвлөрүүлэх үйл ажиллагаа												
Мал хариулах ажил хийх												
Ноолуур борлуулалт												
Ноос борлуулалт												
Гар урлалын зүйлс борлуулах												
Хот суурин газарт очиж ажил хийх												
Аргал, түлш зарах												
Хонь хяргах ажил хийх												
Бусад												
Гол хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх												
Баяр наадам												
Сургалтын төлбөр, хичээлийн хэрэгсэл бэлтгэх												
Хамгийн ихээр зээл авах хугацаа												
Зээлээ эргэн төлөх												
Хоол хүнсний дутагдалтай үе												

Зураг 1: Бүс 01 Улирлын хуанли

Амьжиргааны энэхүү бүсэд малын төллөлт, үржлийн ажил нь зуны намрын бороотой улиралаас хамаардаггүй. Гэхдээ малын хээлтүүлгийн хугацаанд хяналт тавьсанаар мал төллөх хугацааг хүйтэн өвөл дууссаны дараа хавар төллөхөөр зохицуулдаг байна. Сүүний гарц зуны улирал хамгийн дээд хэмжээндээ хүрч, бороо хуртай зуны улирал давхцсанаар бэлчээрийн гарц мөн сайжирдаг. Жилийн хугацаанд малчдын үндсэн орлогоо бүрдүүлэх хоёр гол хугацаа байдаг. Эхний хугацаа нь хавар, зуны (4-8 дугаар сарууд) улирал буюу ноолуур, ноос, сүүн бүтээгдэхүүний

борлуулалт нэмэгдэж, дээд хэмжээндээ хүрдэг хугацаа байна. Дараагийн хугацаа нь намрын улирал буюу 10-11 дүгээр сард малчид өвлийн бэлтгэл болгон мал нядлах ажлаа эхэлдэг. Түүнчлэн амьд малын худалдаа нь 8 болон 9 дүгээр саруудад хичээлийн шинэ жил[5] эхлэхийн өмнө, малчин өрхүүд хүүхдийн сургалтын төлбөр төлөх хугацаатай давхацдаг.

Үнээ мал саах нь цалин хөлстэй ажил биш бөгөөд үндсэндээ гэрийн эзэгтэй, охид бүсгүйчуд малаа сааж, сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах, зах зээлд борлуулах үүргийг ч бас гүйцэтгэдэг байна. Мөн эмэгтэйчүүд малынхаа арьс шир, түүхий эдийг голлон борлуулдаг. Эрэгтэйчүүдийн хувьд бог, бод малаа маллахын зэрэгцээ мал, мах зах зээлд эсвэл ченжүүдэд аваачин борлуулах ажлыг хариуцдаг. Сарлаг саах гол хугацаа нь зун, намар (6-11 дүгээр сар) байна. Зарим малчид зундаа хонь, ямаагаа (6-7 дугаар саруудад) саадаг буюу өвөл саадаггүй. Сарлагийн сүүгээ хонь, ямааны сүүтэй хольж ааруул, тараг, цөцгийн тос үйлдвэрлэдэг байна.

Малчид жилд дөрвөнтөө нүүж, зуслан, намаржаа, өвөлжөө, хаваржаадаа буудаг ба аймаг дотроо 30 километрээс хэтрэхгүй зайд нүүдэллэдэг. Зуны улиралд малчид малаа авч, нам доор газарт, худаг устайгаа ойр зусдаг бол өвлийн улиралд салхины нөмөртэй, цас багатай уул руу нүүнэ. Өвөлжилт хүндрэх үед эрэгтэйчүүд, залуучууд эр, сувай малаа авч оторлон нүүдэллэдэг бол өндөр настан, хүүхэд, эмэгтэйчүүд нь хээлтэй, сул дорой малтайгаа өвөлжөөндөө үлддэг байна.

Нэн ядуу, ядуу малчин өрхүүд ихэнхдээ өвс тэжээлээ өөрсдөө бэлдэхгүй, орон нутгийн хадлан бэлтгэж зардаг хүмүүсээс худалдан авч өвөлжилтийн бэлтгэлээ хангадаг. Амьжиргааны дундаж болон дээд түвшний малчид нь өөрсдөө хадлангийн тоног төхөөрөмж, тээвэрлэх унаатай учраас байгалийн хадлангаа өөрсдөө дангаараа болон хамтран бэлтгэж авдаг. Зуны улиралд малын усан хангамж нь гол, горхи болдог. Зарим малчин өрх нь малын усан хангамжын асуудлаа худагаар шийдвэрлэдэг бол өвлийн улиралд ихэвчлэн цас мөсийг ашигладаг. Ихэвчлэн хүн, малын усны эх үүсвэр нэг байх нь бий.

Нийтэд нь аваад үзвэл бүлэгт хамаарах өрхүүдийн үндсэн орлогоо олдог хоёр гол улирал (дээр дурдсанчлан 4-8 дугаар сар болон 10-11 дүгээр сар) байна. Энэ хугацааны дундуур өмнөх орлогоо зөв зохистой зарцуулан дараагийн орлогын хугацааг хүргэх шаардлага малчдад тулгарч байна. Нэн ядуу өрхүүдээс бусад бүхий л бүлгүүд нь банкнаас зээл авдаг ба ялангуяа 2 дугаар сард (Цагаан сар тэмдэглэх зорилгоор) болон 8 дугаар сард (сургалтын төлбөрт[6]) илүү ихээр зээл авч байна. Улирал бүрийн орлогын томоохон хэсэг нь зээлийн эргэн төлөлтөд зарцуулагддаг. Баяр наадам нь мөн өрхүүдийн хувьд ихээхэн зардал гаргадаг чухал үйл явдал байна. Ихэнх ядуу өрх банкнаас зээл авах боломжгүй тул зардал өндөртэй саруудад дэлгүүрээс хэрэгцээт зүйлсээ зээлээр худалдан авах замаар өр тавьж байна. Энэ тохиолдолд хүү тооцогдохгүй ч зээлийн хэмжээ нь хязгаартай байдаг.

Энэ бүсийн тарчиг/хүнсний хомсдолд нэрвэгдэх хугацаа нь 3-5 дугаар сарууд бөгөөд энэ үед дөнгөж мал төллөж дуусаад сүү цагаан идээ гарч байдаг, мөн сүүний

5 Хичээлийн жил нь 9 дүгээр сараас эхлэн 6 дугаар сарын дунд үеийг хүртэл үргэлжилдэг.

6 (сургалтын төлбөрт)

гарц бага, төл малд үлдээх шаардлагатай байдаг. Эрчүүд намар 10 дугаар сараас эхлэн түлээ, түлш бэлтгэн зарах ажил хийдэг ба энэ нь мөн тусгай зөвшөөрөл(Гоожин) авахыг шаарддаг байна.

Хөрөнгийн задаргаа, үр ашигтай хөрөнгө

		Бүлгүүдийн онцлох шинжүүд					
		Өрхийн хэмжээ	Газар эзэмшил (га)	Бод мал	Бог мал	Хонин толгойд шилжүүлснээр	Бусад үр ашигтай хөрөнгө
Нэн ядуу		4-6 (5)	0-0.07	10-25 сарлаг, 2-4 адуу	15-25 ямаа, 10-20 хонь	100-200	Нарны зай 1, мотоцикл 1
Ядуу		4-6 (5)	0.07	15-35 сарлаг, 5-15 адуу	20-30 ямаа, 20-50 хонь	200-300	Нарны зай 1, мотоцикл 1
Дунд		4-6 (5)	0.07	35-70 сарлаг, 10-25 адуу	35-55 ямаа, 55-100 хонь	300-700	Нарны зай 1, мотоцикл 1, суудлын автомашин 1, ачааны машин 1
Чинээлэг		3-5 (4)	0.07	40-100 сарлаг, 25-65 адуу	100-180 ямаа, 200-550 хонь	1500-2000	Нарны зай 1, мотоцикл 1, суудлын автомашин 1, ачааны машин 1
	0% 20% 40% Өрхүүдийн хувь хэмжээ						

Хүснэгт 3: Бүс 01 Бүлгүүдийн шинж чанарууд

Дээрх хүснэгт дээр бүлэг бүрийн өрхийн эзэмшилд буй хөрөнгийн төрөл, тоо хэмжээг дунджаар тоймлон харуулсан. Хүснэгт дотор буй график нь бүс дотор байгаа, бүлэг бүрт хамаарах өрхүүдийн хувийг харуулсан. Нэн ядуу (15-25%) болон чинээлэг (10-20%) өрхүүд нь бусад бүлгийн өрхтэй харьцуулахад бага хувьтай байна.

Тухайн бүсийн эдийн засгийн үндэс нь мал аж ахуй бөгөөд энэ нь малын тоо толгой нь тухайн өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлогч гол хүчин зүйл болно. Сүүлийн жилүүдэд зудын давтамж нэмэгдсэнээс үүдэн малын тоо толгой буурсан байна. Чинээлэг өрхүүдийн хувьд дундаж бүлгийнхнээсээ (дунд орлоготой бүлэг) бараг хоёр дахин илүү тооны малтай. Тус бүлгийн өрхийн малын тоо нь тухайн судалгааны жилийн хувьд хонин толгойд шилжүүлснээр 1000-1500 малтай байсан бол дундаж өрх 300-700, ядуу 200-300 ба нэн ядуу өрхүүд нь 100-200 малтай байна. Заримдаа ядуу малчид нь чинээлэг малчдад "туслах малчнаар" ажиллаж ажлын хөлсөндөөсар бүр цалин авдаг бөгөөд тухайн өрхөө даган өөрийн цөөхөн малтайгаа нүүдэллэж явдаг. Зарим нь цалингаа бэлэн мөнгөөр авдаг бол зарим нь өөрсдийн хэрэгцээний зүйлсийг авах гэх мэт мөнгөн бус хэлбэрээр цалинждаг байна.

Олон тооны малтай байх нь малчдад энэ чиглэлдээ түлхүү анхаарал хандуулах боломж олгодог тул хонь хяргах, мал хариулах зэрэгт туслах ажилтан авах шаардлагыг багасгаж өгдөг. Цөөн малтай малчид малаа хурдан өсгөхөд хүндрэлтэй.

Ядуу малчдад хэрэгцээтэй зүйлсээ худалдан авахад мөн малаа ямар нэг эрсдэлээс хамгаалах шаардлагатай мэдлэг, ур чадвар дутмаг учраас олон малтай малчдаас илүү малаа хорогдуудаг байна. Иймд түр болон хөлсний ажил хийж орлого олох шаардлагатай болдог.

Сарлаг нь мах, сүү, хөөвөр зэрэг бүтээгдэхүүний улмаас өндөр үнэлэгддэг бөгөөд тухайн судалгааны жилд нэг сарлаг зах зээл дээр ойролцоогоор 500,000 төгрөгөөр зарагдаж байв. Ямаа нь ноолуур болон махны эх сурвалж болох тул үнэ өндөр байна. Бусад бүтээгдэхүүнтэй харьцуулбал хонины ноосны үнэ доогуур ч өрх бүр өөрийн худалдсан ноолуурын килограм тутамд мөнгөн урамшуулал төрөөс авдаг.

Чинээлэг өрхүүд нь бусад гурван бүлгийн өрхүүдтэй харьцуулбал ам бүл цөөтэй. Бүх бүлгийнхэн хүүхдээ дунд сургуульд сургадаг, чинээлэг өрхүүд хүүхдүүдээ дээд болон мэргэжлийн сургуульд сургадаг. Гэхдээ л өв уламжлан мал маллах нь залуусын дунд ихээхэн хүчтэй дэлгэрсэн хандлага байна.

Үнэ төлбөргүй өмчлүүлэх 0.07 га газрыг хүн бүхэн авах боломжтой бөгөөд энэ талаар нутгийн захиргаанд бүртгүүлэн өргөдөл гаргаж холбогдох гэрээ байгуулан эзэмших эрхтэй болдог. Нэн ядуу өрхүүд нь энэхүү боломжийг бага ашиглаж буй нь судалгаагаар тогтоогдсон.

Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийн хувьд чинээлэг болон ядуу малчин өрхүүдийн хооронд ялгаа бага буюу бараг ялгаа байхгүй. Бүх бүлгийн хүмүүс нь зун, намрын удиралд малтайгаа ижил усны эх үүсвэртэй байдаг (гол, нуур, цөөрөм, цасны ус). Чинээлэг болон ядуу өрхүүдийн аль аль нь нүхэн жорлон ашиглаж, хог хаягдлаа ил задгай шатаадаг. Сумын төвд амьдарч буй өрхүүд нь хог хаягдал нэгдсэн хогын цэгт хүргэхэд төлбөр төлдөг. Эрүүл мэндийн үйлчилгээний хувьд бүх бүлгийн хувьд ижилхэн, эмийн ургамал ашиглахаас гадна багийн эмч, сумын эрүүл мэндийн төв болон Цэцэрлэг хот дахь аймгийн эмнэлгүүдээр үйлчлүүлэх боломжтой.

Нөөц эх үүсвэрийн хувьд мал аж ахуйгаас бусад үйлчилгээг авдаг гол ялгаа нь тээврийн хэрэгсэлдээр тулгуурласан харагдаж байна. Дунд орлоготой, чинээлэг өрхүүд нь суудлын болон ачааны машинтай тул өвлийн улиралд тухайн амьдарч буй газраасаа аймгийн төв Цэцэрлэг хот руу саадгүйгээр чөлөөтэй зорчин хүрэх боломжтой. Ядуу өрхүүд ихэнхдээ мотоциклтэй байдаг ба бүх өрх малаа хариулахдаа мотоциклыг ашигладаг.

Хоол хүнсний эх үүсвэр

Доорхи график нь бүлэг тус бүрт хамаарах өрхүүдийн хоол хүнсний эх үүсвэрүүдийг 2015 оны 6 сараас 2016 оны 5 дугаар сарыг хүртэлх хугацааг хамруулан харуулж байна. Зургаадугаар сар нь хэрэглээний жилийн эхлэл бөгөөд учир нь энэ үеэр сүү саалийн цаг эхэлж, хахир тарчиг өвөл, хаврын улирал дуусдаг. Өрхүүдийн хоол хүнсний хэрэглээг 12 сарын хугацаагаар нэг хүнд, өдөрт 2100 килокалори ноогдохоор тооцон харуулсан.



Зураг 2: Бүс 01 Хоол хүнсний эх үүсвэр

Ихэнх өрхийн хувьд-нэн ядуу өрхөөс бусад нь-малын гаралтай (сүү, бяслаг, ааруул, гар тос, тараг болон мах) бүтээгдэхүүнээс авч буй хүнсний илчлэг нь ижил түвшинд байна. Худалдан авдаг гол хүнсний зүйл нь гурил, будаа. Дээр график харуулснаар нийт хүнсний бүтээгдэхүүнээс гурилын хэрэглээ өндөр байгаа бөгөөд бүх бүлгийн 90% нь байна. Тухайн судалгааны жилд гурилын үнэ килограмм нь 1,120 төгрөг байв. Өрхүүд үндсэндээ сард нэг удаа сумын төв орж хэрэгцээтэй хүнсээ худалдан авч, дараа сарынхаа хэрэгцээнд нөөцөлдөг. Зарим тохиолдолд өвөлжилтийн бэлтгэл болгон хүнсээ их хэмжээгээр авч нөөцөлдөг. Нийт өрхүүд бараг ижил нэн тэргүүний шаардлагатай хүнс, бусад хүнсний бүтээгдэхүүн худалдан авдаг, авч буй хэмжээ нь ч ижил буй нь өрхүүдийн ам бүлийн тооны ойролцоо байдлаас хамаарч байна. Ургамлын тос, элсэн чихэр, хүнсний ногоо, гоймон зэрэг нь гурил, будааны дараа орох их хэмжээгээр худалдан авдаг бүтээгдэхүүн байна. Нэн ядуу өрхүүд шаардлагатай илчлэгээ өөрсдийн худалдан авч буй хүнсний бүтээгдэхүүнээс авч байна (60-65%).

Малын гаралтай бүтээгдэхүүний хэрэглээнээс авч буй илчлэг нь үндсэндээ мах (сарлаг, хонь, ямааны) бөгөөд ихэвчлэн зундаа борц, өвөл хөлдөөн хадгалж хэрэглэдэг. Чинээлэг өрхүүдийн хувьд илчлэгийн хэрэгцээний 40% хүртэл хувийг махнаас авч байна. Хүнсний илчлэгийн дараагийн чухал нэг эх үүсвэр цөцгийн тос болон ааруул зэрэг сүүн бүтээгдэхүүн юм. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл зун голлон явагдаж, үйлдвэрлэлийн хэмжээ нь (сарлагаас өдөрт 1-2 литр) бараг хоёр дахин нэмэгддэг. Өрхүүдийн хувьд сүүний хэрэглээ бага бөгөөд худалдан борлуулах боломжтой шар тос, ааруул, тараг, цөцгийн тос хийх илүү сонирхолтой. Өвлийн улиралд хонь, ямаагаа саахгүй, харин зун богийн сүүг сарлагийн сүүтэй хольж дээр дурдсан сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэн эмэгтэйчүүд сумын төв дээр борлуулдаг. Ерөнхийдөө чинээлэг өрхүүд нь хүнс тэжээлээс авах илчлэгийнхээ 60 гаруй хувийг өөрийн үйлдвэрлэсэн малын гаралтай хүнснээс авч байна. Шаардлагатай илчлэгийнхээ нэн ядуу 2 5-30%, ядуу 30-35%, дундаж 40-55%-ийн малын гаралтай бүтээгдэхүүнээс авч байна.

Нэн ядуу, ядуу өрхүүд жилийн шаардлагатай илчлэгийнхээ 6%-ийг чинээлэг болон дунд орлоготой малчдын өгсөн мах, сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангаж байна. Мөн хүнсэндээ хэрэглэж буй самар, жимс зэргээс тодорхой хэмжээний илчлэг авдаг байна. Бага ангийн сургуулийн хүүхэдтэй бүх өрхийн хүүхдүүд сургуулийн үдийн цайнаас мөн тодорхой хэмжээний илчлэг нөхөж авдаг байна. Ядуу өрхүүдийн хувьд сургуульд сурч буй хүүхдүүдийн тоо олон тул шаардлагатай илчлэгээ сургуулийн хүнснээс авч буй хувь хэмжээ өндөр үзүүлэлттэй гарч байна. Цөөн тооны зарим эмзэг өрхүүд сар тутам, нэг хүүхдэд 6,500 төгрөгийн, насанд хүрсэн нэг хүнд 13,000 төгрөгийн үнэ бүхий хүнсний талон авдаг.

Туслах малчнаар ажиллахад заримдаа цалингаа малаар авдаг. Зуны улиралд чинээлэг өрхүүд нь туслах малчиндаа цагаан идээгээр цалингаа олгодог. Жишээ нь туслах малчин нь өдөрт 20 сарлаг саавал 5 сарлагаас саасан сүүгээ өөрөө авч, өрхийн хэрэглээний цагаан идээ үйлдвэрлэж байна.

ШАЛГАХ: Ерөнхийдөө өрхүүд нь хүнсний бусад хэрэгцээний дийлэнх хэсгийг захаас худалдан авдаг. Хамгийн их хэмжээгээр худалдан авдаг гол хүнсний бүтээгдэхүүн нь гурил байна. Бусад хүнсний зүйлсийн тоонд будаа, элсэн чихэр, ургамлын тос, гоймон, хүнсний ногоо (сонгино, байцаа, манжин, лууван) багтана. Сургуулийн хоолноос өрхийн зарим гишүүд (бага ангийн хүүхэд) шаардлагатай илчлэгийн багахан хувийг авдаг. Нэн ядуу өрхүүдийн багахан хэсэг нь сар тутам, нэг хүүхдэд 6,500 төгрөгийн, насанд хүрсэн нэг хүнд 13,000 төгрөгийн үнэ бүхий хүнсний талон авдаг.

Орлогын эх үүсвэр



Зураг 3: Бүс 01 Мөнгөн орлогын эх үүсвэр

ӨРХИЙН ОРЛОГО (ТӨГРӨГӨӨР)				
Бүлэг	**Нэн ядуу**	**Ядуу**	**Дунд орлоготой**	**Чинээлэг**
Өрхийн жилийн орлого	2,000,000-4,000,000	5,000,000-7,000,000	8,000,000-12,000,000	12,000,000-20,000,000

Хүснэгт 4: Бүс 01 Өрхийн орлого

Дээрх зургийн зүүн талд буй график нь жилийн нийт мөнгөн орлогын задаргааг хувиар харуулжээ. Баруун талын график нь орлогын эх үүсвэрээр нь жилийн нийт орлогыг хуваан, төгрөгөөр харуулсан. Бүхий л өрхийн хувьд жилийн үндсэн орлого нь хоёр том хэсгээс бүрдэх бөгөөд нэгдүгээрт хавар, зуны улиралд борлуулдаг ноолуур, ноос, сүүн бүтээгдэхүүнээс, хоёрдугаарт намар болон өвлийн эхэн сард борлуулдаг мах, арьс ширний худалдаанаас гол орлогоо төвлөрүүлж байна. Ихэнхдээ мах, арьс, ширний борлуулалтаас олсон орлогоо хавар хүртэл зарцуулдаг. Гураваас тавдугаар сар нь тарчиг сар бөгөөд орлого бага үедээ авсан зээлээ төлөхөд ч бас зарцуулдаг байна.

Бүх бүлэг нь өөрийн нийт орлогын 50 хүртэл хувийг тухайн жилийн хувьд мал, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнээс олдог. Өрхүүдийн тухайн жилд борлуулсан барааны үнэ нь өрхүүдийн статусаас үл хамааран ижил байна. Судалгаа хийсэн жилийн хувьд дундаж болон чинээлэг өрхүүд нь нийт орлогынхоо 40-50%-ийг нэн ядуу өрх орлогынхоо 20-30%-ийг мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтаас олж байна.

Чинээлэг өрхүүд нь мал ихтэй тул орлогын хувьд малаасаа илүү их хамааралтай. Гэсэн хэдий ч тухайн өрхүүд зээл авах боломжтойн дээр төрөөс нийгмийн халамж мөн авдаг. Төрөөс олгох нийгмийн халамж дэмжлэг нь үндсэн хоёр механизмаар дамжин хэрэгжидэг. Үүний эхнийх нь 18 хүртэл насны хүүхэд бүрт олгодог сар бүрийн 20,000 төгрөг байна. Түүнчлэн боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлсэн хонины ноосны урамшуулалд килограмм тутамд 1,000 төгрөг олгох замаар төрөөс дотоодын боловсруулах үйлдвэрүүдийг дэмждэг. Дундаж болон чинээлэг өрхүүдийн хувьд орлогын эх үүсвэр ижил.

Орлогын хувьд харьцуулбал нэн ядуу өрхүүд мал хариулах, ноос хяргах зэрэг ажлаас ядуу өрхүүдээс илүү орлого олдог байна. Нэн ядуу өрхүүд жилийн нийт

орлогынхоо 25-30%-ийг ажил хийж олдог бол ядуу өрхүүд энэ эх үүсвэрээс орлогынхоо 15-20%-ийг л олж байна. Чинээлэг өрхүүд нь бусдыг хөлслөн ямаагаа самнуулдаг. Эмзэг өрхийн гишүүд энэ ажлын 4-5 дугаар саруудад хийдэг. Нэг хүн өдөрт 6- 10 ямаа самнаж, самнасан ямаа бүрт 2,500 төгрөгийн цалинг судалгаа хийсэн жилд авч байжээ. Хонь ноослох ажлыг ч бас 1-2 сарын хугацаанд хийдэг бөгөөд зуны эхэн сард түлхүү хийдэг. Судалгааны жилийн дүгнээс харахад нэг хүн өдөрт дунджаар 20 хонь хяргаж,тухайн жилд нэг хонь хяргахад 500 төгрөгийн хөлс авч байжээ.

Бүлгүүдийн өрх хоорондзээл олгох, зээл авах үйл ажиллагаа явагддаг бөгөөд чинээлэг малчид нь ядуу малчдад зээл өгөх дургүй байдаг.Тиймээс зээлийн ихэнхийг банкнаас авдаг бөгөөд Малчны зээлийг Хаан Банкнаас авах боломжтой. Энэ зээлийн хүү нь өндөр (ерөнхийдөө сард 2.5% эсвэл жилд 21%). Өрхүүд дахин зээл авах бол өмнө авсан зээлээ эргүүлэн төлсөний дараа шинээр зээл авах боломж бүрддэг. Эргэн төлөлтийн хувьд жилд 2 удаа буюу ноолуур гарах үед болон мал, мах бэлтгэлийн үеийг тааруулан хийдэг ажээ.

Ядуу өрхүүд нь орлогын эх үүсвэрийн хувьд нилээд их төрөлжсөн, жишээ нь түлшний мод борлуулж бага хэмжээний орлого олдог. Энэхүү үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл (гоожин) авсан байхыг шаарддаг ч нэн ядуу өрхүүдийн хувьд бараг боломжгүй шаардлага юм.

Дараагийн графикт дурдсан графиктай ижил мэдээлэл оруулсан бөгөөд энэ тохиолдолд банкны зээлд хамаарах мөнгөн орлогыг оруулаагүй. Эдгээрийг дараагийн график болох зээлийн эргэн төлөлтийг багтаасан зарцуулалтын графиктай харьцуулан харж болно (бүтнээр нь бус).



Зураг 4: Бүс 01 Орлогын эх үүсвэр, банкны зээлээс бусад

Зарцуулалт

Энэхүү график дээр 2015 оны 6 сараас 2016 оны 5 дугаар сарыг хамаарах хугацааны зарцуулалтын ерөнхий хэв шинжийг харуулж байна. Эд хөрөнгийн хэмжээнээс хамааран абсолют зардал нь нэмэгдэж буйн зэрэгцээ график дээр харуулсан зарцуулалтын задаргаа нь төрөл бүрийн ангилал дээрх зарцуулсан орлогын дүнг харьцангуй утгаар нь харуулж байна.



Зураг 5: Бүс 01 Зардлын хэв шинжүүд

Нэн хэрэгцээт хүнсний зүйл, түүнчлэн хүнсний хэрэглээний зүйлсэд зориулан өөрийн орлогоос өрхийн зарцуулж буй хувь хэмжээ нь бүлгээс хамааран буурч байна. Нэн ядуу өрхүүд орлогынхоо дөрөвний нэг орчим хувийг хүнсэнд зарцуулж буй бол бусад бүлгийн хувьд энэхүү хувь хэмжээ 10 орчим эсвэл үүнээс доогуур байна.

Нэн ядуу өрхүүд нь орлогынхоо 6 орчим хувийг баяр наадамд зарцуулдаг нь тээвэрт (орц хэмээх ангилалд багтсан) зарцуулдаг мөнгөн дүнтэй нь бараг ижил байна. Баяр наадам нь малчдын нийгмийн арга хэмжээний чухал нэг хэсэг байхын зэрэгцээ өрхүүд энэ үеэр шинэ хувцас бэлтгэхэд ихээхэн мөнгийг зарцуулж байна. Ядуу, дунд болон өндөр орлоготой хэсгийн "бусад зардал" хэмээх ангилалд хадгаламж мөн багтаж байна.

Нийгмийн үйлчилгээний ангилалд сургууль/сургалтын төлбөрийн зардал, эрүүл мэнд, эм, эмчилгээний зардал багтана. Бусад бүлэгтэй харьцуулбал нэн ядуу өрхүүд нь орлогынхоо ихээхэн хувийг эдгээр үйлчилгээнд зориулан зарцуулдаг. Хоол хүнс, өрхийн хэрэглээний зүйлс, тээвэр, боловсрол, шаардлагатай чухал хэрэглээний зардлуудаа эхлэн санхүүжүүлсний дараа нэн ядуу өрхүүдэд орлогынх нь гуравны нэг орчим нь үлддэг бөгөөд түүнийгээ хувцас хунар болон бусад хэрэглээний зүйл

болох архи, гоо сайхны бараа бүтээгдэхүүн, баяр ёслол зэрэгт зарцуулдаг байна. Нэн ядуу өрхүүд нь орлогынхоо 6 орчим хувийг баяр ёслолд зарцуулдаг ба түүнтэй бараг ижил мөнгөн дүнтэй зарлага унаа тээвэрт (бусад хэрэглээ хэмээх ангилалд багтсан) зарцуулагддаг байна. Малчдын нийгмийн арга хэмжээний чухал нэг хэсэг нь баяр ёслол байхын зэрэгцээ малчид энэ үеэр шинэ хувцас бэлтгэхэд ихээхэн хэмжээний мөнгө зарцуулдаг. Ядуу, дунд болон чинээлэг бүлгийн малчдын "бусад зардал" хэмээх ангилалд хадгаламж мөн багтсан болно.



Зураг 6: Бүс 01 зардлын хэв шинж, зээлийн үндсэн төлбөр оруулсан

Амьжиргааны хувьд боломжтой бүлгийн өрхүүд нь өрхийн орлогын тал орчим хувийг малын эм, давс хужир, ажилчин хөлслөх, тэжээл худалдан авах болон хашаа хороо засах зэрэг хэрэгцээний зүйлсийг худалдан авахад зарцуулдаг. Эмзэг болон дундаж өрхүүдийн хамгийн томоохон зардлын ангилалд зээлийн төлбөр байгааг дээрх график дээр харуулсан бөгөөд үүнд тухайн өрхүүд орлогынхоо дөрөвний нэгээс гуравны нэг хүртэлхийг зарцуулдаг байна.

Зүүн талд буй график нь зээлийн хүүгийн төлбөрийг оруулалгүйгээр (зөвхөн үндсэн зээлийг оруулж) зардлын хэв шинжийг тусган харуулав.

Мал сүргийн шилжилт, нүүдэл

Архангай аймгийн өндөр уулын бүсийн мал аж ахуйн амьжиргааны бүсэд ерөнхийдөө мал сүргийн нүүдлийг жилдээ дөрөвөөс багагүй удаа хийгддэг. Тухайн судалгааны жилийн хугацаанд бүх бүлэг өөрийн малаа авч, бэлчээр сэлгэн нүүдэллэдэг. Үүнд уналгын мал, эм мал, хөхүүл мал болон төл мал орно. Бүх бүлгийн мал сүргийн доторх харьцааны хувьд нийт сүргийн гуравны нэг орчим нь нас гүйцсэн эм мал байдаг байна.

Ихэнхдээ малчид 15-30 километр зайтай нүүдэг. Тэдний хувьд амьжиргааны бүсээс гадагш бараг нүүхгүй, өвөл цаг хүндрэх юм бол Архангай аймгаас гадагш гарч нүүх тохолдол байдаг. Зуслангийн тухайд нам дор голын сав газарт худаг усандаа ойр буудаг. Малчин өрхүүд 8-9 дүгээр сард зуслангаасаа 15-30 километр хүртэл зайд нүүдэллэн намаржаандаа бууна. Намаржаа нь ихэвчлэн хэт өндөрт бус дунд зэргийн өндөртэй газарт байрладаг. 11 дүгээр сарын сүүл, 12 дугаар сарын эхээр өвөлжөөндөө буух ба өвөлжөө нь салхинаас хамгаалах нөмөртэй газар байдаг. Малын хашаа хорооны хаалгыг зуун урд зүгт харуулан барьдаг нь баруун хойноос үлээх салхинаас хамгаалахад тустай. Өвөлжөө нь намаржаанаас ойролцоогоор 15-20 км зайтай байдаг. Хаваржаа нь өвөлжөөнөөс 15 км орчим зайтай, нуурын дагуу, эсвэл зуслантай цуг байна. Зарим тохиолдолд малчид өвлийн бэлчээрээ өнжөөж өөр газарт буух замаар сэргээдэг. Энгийн үед гэр бүлээрээ малтайгаа хамт нүүдэг.

Цаг хүндрэх эсвэл зуд турхан тохиох үед эрэгтэйчүүд нь эр, сувай сарлаг малаа авч уул руу нүүж, эмэгтэйчүүд нь хээлтэй малтайгаа нам доор газар үлдэнэ. Цаг агаарын хүндрэл тохиох үед энгийн бусад жилээс ялгаатай нь илүү хол бэлчээр сайтай газарт оторлон өвөлжих ба аймгаасаа гарч 300 гаруй км нүүх ч тохиолдол байдаг.

Судалгаа хийсэн жилийн тухайд бүсийн хэмжээнд мал төллөлт, борлуулалт, хорогдол, нүүдлийн хэв шинж зэрэг нь хэвийн байсан.

Хариу арга хэмжээний стратегиуд

- **Ядуу өрхүүд** нь хүнд өвлийг хүндрэл багатай давах зорилгоор хадлан хадах, худалдан авах зэргээр **малын тэжээл бэлтгэдэг** бөгөөд үндсэндээ радиогоор сонссон мэдээлэлдээ үндэслэн шийдвэр гаргадаг байна. Тэд мөн нядалсан малынхаа дотор эрхтнийг, хивэг болон хужир бусад эрдэстэй хольж малдаа нэмэлтээр өгдөг.
- **Ядуу өрхүүд нь** чинээг, олон малтай айлд **туслах малчнаар** ажиллаж, бүх малаа зудад алдсан зарим малчид нь хот суурин газарт шилжин суурьшдаг байна.
- **Чинээлэг өрхүүд** нь өвлийг даван туулах стратегийн хүрээнд **бог, бод малаа олон тоогоор борлуулж**, олсон мөнгөөрөө бусад малдаа орон нутгаас өвч авах эсвэл Улаанбаатар хотоос хивэг авчран зардаг худалдаачдаас тэжээл худалдан авах зэргээр нөөц бүрдүүлдэг.
- Өрхүүд нь мөн малаа авч **бэлчээртэй газарт оторлох** замаар өвлийг даван туулж байна.

Гол үзүүлэлтүүд

Доор буй хүснэгтэд жагсаасан гол үзүүлэлтүүд нь *Архангай аймгийн өндөр уулын, мал аж ахуйн амьжиргааны бүсийн* өрхийн эдийн засагт томоохон хувь нэмэр оруулдаг гол хүнс, орлогын эх үүсвэрүүд юм. Эдгээр үзүүлэлтүүдийн орон нутгийн эдийн засагт оруулж буй үр шим, алдагдлыг байнгын мониторингийн систем эсвэл тодорхой хугацааны давтамжтай хийгдэх үнэлгээгээр тодорхойлон гаргаж байх шаардлагатай.

Item	**Гол үзүүлэлт-Тоо хэмжээ**	**Гол үзүүлэлт-Үнэ**
Мал аж ахуйн үйлдвэрлэл	• Сарлагийн сүү (тоо хэмжээ) (өвөл, зун) • Өөрийн малын мах • Бусдаас мах өгөх (хэмжээ) • Адуу зарж борлуулах • Сарлаг зарж борлуулах • Ямаа зарж борлуулах • Хонь зарж борлуулах • Ноолуур самнах, хонь хяргах • Мал хариулах • Ноолуур борлуулах • Ноос худалдах	• Сарлагийн сүү, өрөм/шар тос борлуулах (өвөл, зун) • Адуу зарж борлуулах • Сарлаг зарж борлуулах • Ямаа зарж борлуулах • Хонь зарж борлуулах • Ноолуур самнах, хонь хяргах • Мал хариулах • Ноолуур борлуулах • Ноос худалдах
Бусад хоол хүнс болон мөнгөн орлого	• Нийгмийн халамж, тусламж • Зээл	• Нийгмийн халамж, тусламж • Зээл

Хүснэгт 5: Бүс 01 Гол үзүүлэлтүүд

Хөтөлбөрийн үзүүлэх нөлөөлөл

Хөтөлбөрийн зүгээс судалгаанд хамрагдсан хүмүүсийн өөрсдийн гаргасан шийдэл, санал, орон нутагт хийсэн ажилглалт, хэлэлцүүлгийн хүрээнд гаргасан санал шийдвэрүүдийг тусган дараах дүгнэлтийг хүргэж байна. Эдгээр санал дүгнэлтэд үндэслэн цаашид боломжит судалгааг (feasibility study) хийх шаардлагатай.

- Орон нутгийн аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж, сум, аймгийн төвүүдэд ажын байр бий болгох боломжийг хангах. Орон нутагт ажлын байр хомс, нөгөө талаар нутгийн иргэд өөр газарт шилжин очсон ч ажил олдохгүй байна.
- Бэлчээрийн доройтол, талхлагдлаас сэргийлэхийн тулд малын тоо толгойтой уялдуулан бэлчээр ашиглалтын татварыг бий болгож хэрэгжүүлэх.

- Малчдын мал, мал аж ахуйн бүтээгдэхүүний худалдааны зах зээлийн хүртээмжийг сайжруулах. Аймгийн төв эсвэл Улаанбаатар хүртэл явах боломжтой малчид өөрийн бүтээгдэхүүнээ шууд, өндөр үнээр зарж буй тул үүнтэй холбоотой зах зээлийн системийг сайжруулах арга зам байж болно.
- Малчин өрхүүдийн арун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл байдлыг сайжруулах.
- Хүнсний бүтээгдэхүүн хадгалах, бэлтгэх арга зүй, хоол тэжээллэгийн олон янз байдал, ялангуяа хүнсний ногооны төрөл бүрийн хэрэглээний талаарх мэдлэгийг сайжруулах.
- Уламжлалт мал маллагааны арга техникийг залуу малчдад заан сургах.
- Залуу малчдын боловсрол эзэмших боломжуудыг сайжруулах.

2. Өрхийн эдийн засгийн шинжилгээний суурь мэдээлэл: Сүхбаатар аймгийн тал хээрийн бүсийн мал аж ахуйн амьжиргааны бүс

2018 оны 1 дүгээр сар

Амьжиргааны бүсийн танилцуулга

Сүхбаатар аймгийн тал хээрийн, мал аж ахуйн амьжиргааны бүс[7] нь Монгол улсын дорно хэсгийн Сүхбаатар аймагт оршино. Хагас цөлөрхөг, хуурай уур амьсгалтай энэ бүс нутаг нь үндсэндээ ил өвс бүхий тэгш тал газраас бүрдэнэ. Тус аймаг нь Монгол улсын зүүн өмнөд хэсэгт оршиж, өмнөд хэсгээрээ БНХАУ, баруун, зүүн болон хойд хэсгээрээ Дорноговь, Хэнтий, Дорнод аймгуудтай хил залгана. Тус аймгийн өмнөд болон хойд хэсгээр уул, толгод болон сөнөсөн галт уул элбэг байх ба эдгээрийн хооронд өргөн уудам тал нутаг үргэлжилдэг. Гадаргын усны нөөц маш бага, байнгын урсгалтай гол байхгүй, цөөн тооны жижиг нуур цөөрөм, горхи, булагтай. Дундаж өндөр нь далайн түвшнээс дээш 1100 метр орчим. Цаг уурын хувьд зун +40С хэм хүртэл халж, өвөл -40С хэм хүртэл хүйтэрдэг. Аймгийн төв Баруун-Урт хот нь Улаанбаатар хотоос 565 км зайтай. Аймгийн хүн амын нягтрал бага, нэг хавтгай дөрвөлжин метр газарт нэг хүн ноогдоно. Тээврийн дэд бүтэц нь орон нутгийн бусад аймагтай ижил. Хатуу хучилттай зам Улаанбаатар болон Баруун-Урт хотыг холбодог. Бусад сумд хоорондын замууд нь хатуу хучилтгүй шороон зам байна.

Амьжиргааны энэ бүсийн хүн ам нь үндсэндээ нүүдэллэн амьдардаг малчин өрхүүдээс бүрдэнэ. Суурин газрын оршин суугчид, сумын төвд байнга суурин амьдардаг хүмүүсийг энэхүү суурь судалгаанд хамруулаагүй. Монгол улсын хувьд албан ёсны амьжиргааны бүсчлэлийг гаргаагүй тул *Тал хээрийн мал аж ахуйн амьжиргааны бүс* нь зөвхөн Сүхбаатар аймгийн хилээр хязгаарлагдахгүй байж болно. Энэхүү судалгааны ажлыг Сүхбаатар аймгийн Халзан, Дарьганга, Онгон, Баяндэлгэр, Уулбаян, Асгат, Мөнххаан, Түмэнцогт сумдад хийж гүйцэтгэсэн.

Энэ бүсийн малчдын амьжиргаа нь мал бөгөөд малчид үндсэндээ хонь, ямаа, үхэр, адуу болон цөөн тоогоор тэмээ өсгөдөг. Тус бүс нь хурдан удмын адуугаар нэрд гарсан тул Монгол улсын өнцөг булан бүрээс хүмүүс Сүхбаатар аймагт ирж, морь худалдан авдаг. Аймгийн хэмжээнд мал бүтэн жилийн туршид бэлчээрийн маллагаатай. Зөвхөн ядарч, доройтсон, хээлтэй малыг хавар (3-5 дугаар саруудад) ногоо ургатал тэжээжонд оруулдаг. Ихэнх малчид хужир, өвсийг өөрсдөө бэлтгэх худалдан авах замаар бэлтгэдэг. Цаг хүндрэх үед ТББ-ууд өвс тараах, Засгийн газраас хөнгөлөлттэй үнээр өвс олгох арга хэмжээ авдаг. Малын усан хангамжийн асуудлыг худаг, жижиг горхи, булаг шанд, цасны усаар шийднэ. Бүх төрлийн малыг арилжаалдаг ба Баяндэлгэрийн улаан ямааны ноолуур нь чанар сайтай арилжааны гол орлого олдог бүтээгдэхүүний нэг юм. Үүний дараа ноос, арьс ширний борлуулалт орно. Үнээний сүүг өрхүүд дотоодын хэрэгцээндээ хэрэглэдэг ч зарж борлуулдаггүй.

7. Энэхүү нөхцөл байдлыг тодорхойлох хээрийн судалгааны үйл ажиллагааг 2017 оны 11 дүгээр сард хийсэн. Тус тодорхойлолт дээр багтсан мэдээлэл нь 2016 оны 6 дугаар сараас 2017 оны 5 дугаар сарыг хүртэлх хэрэглээний жил болох тухайн жилд хамааралтай мэдээлэл юм. Эдийн засагт ямар нэгэн суурь эсвэл гэнэтийн өөрчлөлт гарахгүй хэмээн үзвэл энэхүү тодорхойлолтод багтсан мэдээлэл нь ойролцоогоор 5-10 жилийн хугацаанд хүчинтэй байж болно (жишээ нь 2022-2027 оныг хүртэл). Баримт бичигт дурдагдсан бүхий л үнэ нь тухайн хамаарах жилийнх болно

Бусад төрлийн малыг сааж, сүүг нь ашигладаггүй. Үржлийн хээлтэгч малыг сүргээсээ сэлбэдэг бөгөөд малчид мал худалдан авах нь түгээмэл бус. Амьд малын арилжаа нь мал тарга хүчээ сайн авсан зун, намар улиралд хийгддэг ба энэ үед эрэлт өндөр мөн малчдын мөнгөний хэрэгцээ хамгийн их байх мөчтэй давхацдаг. Ноолуурыг 3-4 дүгээр саруудад самнаж, ноосыг 6-8 дугаар саруудад хярган борлуулдаг. Өвлийн улиралд малаас олох орлогын хэмжээ маш бага. Ядуу өрхүүд нь чинээлэг малчдын хонь хяргах, мал хариулах зэрэг ажил хийж дутагдаж буй орлогоо нөхөж байна.

Малчин өрхүүд нь жилд дөрвөн удаа нүүж, ойролцоогоор 20 км зайтай зуслан, намаржаа, өвөлжөө, хаваржаандаа буудаг. Малчид нүүхдээ орон нутгийн захиргаанаас газар, бэлчээр ашиглах эрх авдаг. Өвөлжилт хүндэрч зуд болоход голдуу эрчүүд эр сувай малаа аван бэлчээр сайтай газар хайж ойролцоогоор 150 км орчим зайд нүүдэллэдэг бол өрхийн бусад гишүүд сул дорой малтайгаа (өвчтэй, хээлтэй, төл болон хөгшин мал) өвөлжөөндөө үлддэг. Энэ бүсийн мал аж ахуйн үйлдвэрлэл нь байнгын ган, зуд, малын халдварт өвчний гаралтаас хамааран ихээхэн сөрөг нөлөөнд өртөж байна. Сүхбаатар аймаг нь шүлхий, хонины цэцэг өвчний голомт бүхий нутаг юм.

Хүн, малын ундны усан хангамж нэг эх үүсвэртэй бөгөөд үнэ төлбөргүй. Өрхүүд нь энгийн нүхэн жорлон хэрэглэх ба хогоо шатааж устгадаг. Эрүүл мэндийн үйлчилгээг багийн эмчээс, сумын болон аймгийн эрүүл мэндийн төвөөс эрүүл мэндийн даатгалтай иргэд авах боломжтой. Ихэнх өрхүүд гэрэл гаргах зориулалт бүхий нарны батарейтай, харин хоол хийх, дулаацуулах зорилгоор аргалыг түлшиндээ хэрэглэнэ. Сум тус бүр бага, дунд сургуультай бөгөөд хүүхдүүд үнэ төлбөргүй суралцаг. Малчин өрхүүд хэдийгээр нүүдэллэн амьдардаг ч гэсэн хүүхдээ сургуульд хамруулдаг. Том хүүхдүүд нь сургуулийн дотуур байр, хамаатан садныдаа амьдардаг. Бага насны хүүхдүүдтэй малчин өрхийн зарим нь хуваагдан нэг хэсэг нь хүүхдээ харж 9 сараас 6 сарын дунд хүртэл сумын төвд амьдрах тохиолдол элбэг. Багадаа 100 малтай өрхийн хувьд банкны зээл авах боломжтой байдаг бол цөөн малтай хэсэг нь шаардлагатай бараа бүтээгдэхүүнээ дэлгүүрээс зээлээр худалдан авдаг. Ихэнх өрхүүд хамгийн багадаа нэг гар утас хэрэглэдэг ч ихэнх алслагдсан газруудад харилцаа холбоо хүндрэлтэй хэвээр байна.

Амьд мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг (ноолуур, ноос) борлуулах ажлыг эрэгтэйчүүд хариуцахын зэрэгцээ хонь ноослох, мал маллах, услах, хашаа хороо барих, засаж сэлбэх, морь уях, аргал түлш түүх, хадлан хадах, малын худаг ус гаргах, гэр барих зэрэг ажлыг ч мөн хийдэг. Эмэгтэйчүүд нь мал саах, сүү цагаан идээ боловсруулах, хоол хүнсээ бэлтгэх, хүүхдээ асрах, эсгий хийх, хувцас оёх зэрэг ажил үүргийг хариуцахын зэрэгцээ хавар, зун мал хариулах, ямаа самнах, өвчтэй мал эмчлэх зэрэг ажилд тусалдаг.

Зах зээл, зах зээлийн хүртээмж

Сүхбаатар аймгийн тал хээрийн, мал аж ахуйн амьжиргааны бүс нь Монгол улсад түгээмэл байдаг, алслагдсан газрын нэг юм. Улаанбаатар хотыг тус аймагтай холбосон хатуу хучилттай замын нөхцөл байдал сайн. Аймгийн доторх замууд хатуу хучилтгүй, шороон замууд бөгөөд замын нөхцөл байдал муугүй, гэхдээ зүг чиг баримжаалах томоохон уул байхгүй. Ялангуяа өвөл их цас орох үед зам тээврийн нөхцөл байдал хүндрэн, зах зээлийн хүртээмж мууддаг. Ихэнх өрхүүд мотоцикл, ачааны машин, трактор ашиглан хамгийн ойр байгаа сум орон нутгийн зах зээлд хүрдэг. Зарим өрхүүд өвөл эхлэхээс өмнө хүнсний болон шаардлагатай бусад зүйлсийг худалдан авч нөөцөлдөг. Ихэвчлэн чинээлэг болон дундаж өрхүүд нь эмзэг бүлгийн өрхтэй харьцуулахад нөөц бэлдэж авах нь хялбар байдаг.

Амьд үхэр, хонь, ямаа, ноолуур, ноос болон арьс, ширийг сумын зах зээлээс аймагт, цаашлаад Улаанбаатар хотын зах зээлд хүргэдэг. Ноолуурын хувьд үндсэндээ эцсийн хэрэглэгч болох Хятад улс руу гардаг. Аймагт үйлдвэрлэсэн ноосны ихэнх нь Улаанбаатар хот дахь хивс, эсгий үйлдвэрлэгчдэд хүргэгддэг бол арьс, ширний зарим хэсэг нь нийслэлд буй боловсруулах үйлдвэрүүдэд хүрч, үлдсэн хэсэг нь экспортод гарч байна. Хувь хүмүүс хил дамнуулан амьд мал Хятад руу зарах нь хууль бус үйлдэл хэмээн тооцогдох ба зөвхөн зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд л мал, мах гаргадаг. Харин адууны хувьд малчид шууд бусад аймгуудад борлуулж байна.

Нэн эмзэг, эмзэг өрхүүд тус бүсийн ур чадвар бага шаардсан, биеийн хүчний ихэнх ажлыг хийж байна. Ажлын гол төрлүүд нь чинээлэг малчид бусдыг хөлслөн мал маллуулах, хонь хяргуулах (мөн ямаа самнах) зэрэг ажил байна. Ядуу малчин өрхүүд нь чинээлэг малчдын туслах малчнаар ажиллаж, цалингаа бэлэн мөнгөөр эсвэл ямар нэгэн эд зүйлээр авч байна (мал эсвэл бусад бүтээгдэхүүн).

Зардлын хувьд Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дорнод аймгуудад тариалсан улаан буудайгаар Улаанбаатар хотод үйлдвэрлэсэн гурилыг худалдаачид аймаг, сумын төвүүдэд тээвэрлэн авчирч зардаг бөгөөд тухайн сумын төвийн дэлгүүрүүдээс малчид гол худалдан авалтаа хийдэг. Гантай жилүүдэд улаан буудайн ургацын хомсдол үүсэх үүнийг ОХУ-аас улаан буудай импортлон оруулж ирэх замаар нөхдөг. Будаа, элсэн чихэр, ургамлын тосыг мөн гадаадаас импортолдог бөгөөд Улаанбаатар хотоор дамжин, цаашид хөдөө орон нутгуудад түгээгдэн, зарагдаж байна.

Зарим өрхүүд өөрсдөө хадлангаа бэлдэж авдаг бол нөгөө хэсэг нь хадлан бэлтгэдэг бизнес эрхлэгчдээс шууд худалдан авдаг. Хивэг, малын шахмал тэжээлийг наймаачид Улаанбаатар хотоос худалдан авч Сүхбаатар аймагт зарж байна.

Улирлын нөлөө, хугацаа, тулгарах аюул/гамшиг

Энэхүү судалгаа нь "судалгаа хийсэн жил" хэмээн нэрлэгдэх өвөрмөц онцлог бүхий хугацааг хамран хийгдсэн. *Сүхбаатар аймгийн тал хээрийн, мал аж ахуйн амьжиргааны бүсэд* энэхүү судалгаа хийсэн жил нь 2016 оны 6 дугаар сараас 2017 оны 5 дугаар сарыг хүртэлх хэрэглээний жилийн хугацааг хамарсан. Малчдын бүлэг, хоршооны ахлагчдаас[8] судалгаа авахдаа тухайн орон нутгийн сүүлийн таван жилийг улирлын хувьд ангилаад тухайн жилийг хамгийн тааламжтай байснаар нь 1-5 хүртэл оноогоор (1 хамгийн тааламжгүй, 5 хамгийн таатай) Бүсийн ихэнх хэсгийн хувьд тухайн сонгон авсан лавлагаа хугацаа нь тааламжтай байдлын хувьд дундаж буюу 3 гэсэн оноогоор үнэлэгдэж хур тунадастай, бэлчээрийн гарц, малын зүй бус хорогдол, өвчний дэгдэл зэрэг нь хэвийн зуд болоогүй гэж үнэлэгджээ.

Судалгаанд оролцогчдын мэдээлсэнээр гол аюулт үзэгдэлд зуд (5 жилээс нэгд нь), ган (5 жилээс нэгд нь), хээрийн түймэр (3 жилд нэг) болон малын халдварт өвчний гаралт (шүлхий, хонины цэцэг) багтаж байна. Хүчтэй салхи, шороон шуурга жил бүр болдог.

Хэдийгээр амьжиргааны энэхүү бүс нь хуурай уур амьсгалтай ч 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл үргэлжлэх хур бороотой улирал нь бэлчээр нөхөн сэргээх, цаашдын усны хэрэглээг хангах зэрэг ач холбогдолтой тул улирлын хуанлид багтах чухал хугацаа байдаг. 10 дугаар сараас эхлэн 3 дугаар сарыг хүртэл цас ордог боловч 11 сараас 1 дүгээр сарын хооронд хамгийн их цас ордог. Хавар орой гэнэтийн хүчтэй салхи ихээр гарах тул малчид хаваржаагаа сонгохдоо малын хашаа хороонд нөмөр газар бараадан сонгох нь бий.

Малын хээлтүүлгийн хугацаанд хяналт тавьсанаар мал төллөх хугацааг хүйтэн өвөл дууссаны дараа хавар төллөхөөр зохицуулдаг байна. Энэ үеэр бэлчээрийн ургац бага байдаг ч хахир өвөл дуусаж, шинэ төллөсөн малыг ногоо ургах хүртэл тэжээдэг. Бэлчээрийн гарц 6 дугаар сараас эхлэн сайжирдаг тул сүүнийг гарц нэмэгдэж 10 дугаар сарыг хүртэл малчид үнээгээ саадаг. Амьжиргааны энэ бүсэд ихэвчлэн үхэр, хонь, ямаа, адуу зэргийг үржүүлж өсгөдөг бөгөөд эдгээр нь жилд нэг удаа төллөдөг. Малын өвчин хүйтэн улирал эхлэхийн өмнө эсвэл дууссаны дараа гарч дээд цэгтээ хүрдэг.

Амьд малын худалдаа нь ихэвчлэн 7 сараас 11 сарын хооронд хийддэг бөгөөд энэ үед мал нь өвлийн алдсан жингээ нөхөж тарга хүч авч эрүүл болсон байдаг. Малчин өрхүүдийн хувьд энэ үеэр байнгын зардал гарч, орлого олох шаардлага үүсдэгийн жишээнд 7 дугаар сард Наадам тэмдэглэх, 8-9 дүгээр саруудад хичээлийн бэлтгэл хийх, сургалтын төлбөр төлөх, 10-11 дүгээр саруудад өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зэрэг зардал гардаг байна. Нэгдүгээр сарын сүүл, хоёрдугааар дугаар сард үндэсний баяр "Цагаан сар" болдог тул мөн эдгээр саруудд нь зарлага өндөртэй сарын тоонд ордог. Тухайн бүсийн хувьд малчин өрхүүдийн өвөл орлого олох боломж хязгаартай тул олон хүн энэ үеэр зээл авдаг байна. Авсан зээлээ мал, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний худалдаа эргэн сэргэж, дээд хэмжээндээ хүрэх үед эргүүлэн төлж байна.

8 Орон нутгийн түвшинд хийсэн ярилцлагад оролцогчдын тоонд багийн дарга нар, сумын ЗДТГ-ын албан тушаалтнууд, дарга, мал аж ахуйн тасгийн дарга, мал аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд, Засаг даргын орлогч, малчдын бүлгийн ахлагч нар хамрагдсан.

Лавлах хамаарах он												
	Зун			Намар			Өвөл			Хавар		
	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар
Мал												
Бороо хуртай улирал												
Цас												
Хүчтэй салхи												
Үхэр												
Орооны цаг/үржил, хээлтүүлэг												
Мал төллөлт												
Борлуулалт												
Сүүний үйлдвэрлэл												
Хонь ямаа												
Орооны цаг/үржил, хээлтүүлэг												
Мал төллөлт												
Мал төллөлт												
Борлуулалт												
Сүүний үйлдвэрлэл												
Адуу												
Адуу зарах												
Малын өвчин												
Отор нүүдэл												
Орлого төвлөрүүлэх үйл ажиллагаа												
Мал хариулах ажил хийх												
Ноолуур борлуулалт												
Ноос борлуулалт												
Гар урлалын зүйлс борлуулах												
Хадлан хадах												
Хонь хяргах ажил хийх												
Бусад												
Гол хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх												
Баяр наадам												
Ан агнуурын гол хугацаа												
Сургалтын төлбөр												
Хамгийн ихээр зээл авах хугацаа												
Зээлээ эргэн төлөх												
Хүнсний дутагдалтай үе												

Зураг 7: Бүс 02 Улирлын хуанли

Энэхүү бүсийн малчдын зарж буй гол бүтээгдэхүүн нь ноос, ноолуур байдаг. Гурав болон дөрөв дүгээр сард ямаагаа самнаж, ноолуураа зарж борлуудлаг бол зургаан сараас эхлэн 8 дугаар сарыг хүртэл ноосоо борлуулдаг. Ноос нь үнэ хямд байдаг. Бусад бүсээс ялгаатай нь амьжиргааны энэ бүсэд сүү, сүүн бүтээгдэхүүний худалдаа түгээмэл биш, зөвхөн өөрсдийн хэрэгцээнд ашиглаж байна. Малчид зөвхөн үнээгээ л саадаг.

Нүүдлийн хувьд жилд дөрвөөс доошгүй удаа бөгөөд энэ талаар "Мал сүргийн шилжилт нүүдэл" хэмээх хэсэгт дэлгэрэнгүй дурдсан. Малчид 3 дугаар сард хаваржаандаа, 6 дугаар сард зусландаа, 9 дүгээр сард намаржаандаа, 12 дугаар сарын эхээр өвөлжөөндөө тус тус нүүдэллэн буудаг.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн хувьд ан агнуурын хийх нь хууль бус учраас энэ талаар ярихаас татгазаж байсан ч энэ бүсийн хувьд ганц нэг зээр, тарвага ангах явдал гардаг байна. Ан агнуурыг өвөл эхлэхээс өмнө 10-11 дүгээр сард ихэвчлэн хийдэгг байна.

Энэхүү бүсийн малчин өрхүүдийн тарчиг үе нь сүү сааль гарахын өмнөх хаврын улирал байдаг ажээ.

Эд хөрөнгийн задаргаа, үр ашигтай эд хөрөнгө

		Бүлгүүдийн шинж чанарууд					
		Өрхийн хэмжээ	Газар эзэмшил (га)	Бод мал	Бог мал	Хонин толгойд шилжүүлснээр	Бусад үр ашигтай хөрөнгө
Нэн ядуу		4-6 (5)	0-0.07	5-10 үхэр, 3-7 адуу	20-30 ямаа, 15-25 хонь	70-150	Нарны зай 1, мотоцикл 1
Ядуу		4-6 (5)	0.07	6-14 үхэр, 5-10 адуу	45-60 ямаа, 40-60 хонь	150-250	Нарны зай 1, мотоцикл 1
Дунд		4-6 (5)	0.07	10-20 үхэр, 10-25 адуу	65-125 ямаа, 70-140 хонь	250-500	Нарны зай 1, мотоцикл 1, суудлын автомашин 1, ачааны машин/ трактор 1
Чинээлэг		3-5 (4)	0.07	35-70 үхэр, 30-90 адуу, 0-5 тэмээ	180-270 ямаа, 250-500 хонь	1000-1500	Нарны зай 1, мотоцикл 1, суудлын автомашин 1, ачааны машин/ трактор 1

0% 20% 40% 60%

Өрхүүдийн хувь хэмжээ

Хүснэгт 6: Бүс 02 Бүлгүүдийн шинж чанарууд

Дээрх хүснэгт дээр бүлэг бүрийн өрхийн эзэмшилд буй хөрөнгийн төрөл, тоо хэмжээг дунджаар тоймлон харуулсан. Хүснэгт дотор буй график нь бүс дотор байгаа, бүлэг бүрт хамаарах өрхүүдийн хувийг харуулсан. Эндээс харахад дундаж орлоготой бүлэг нь хамгийн их хувьтай байна.

Орон нутгийн эдийн засгийн үндэс нь мал аж ахуй бөгөөд энэ нь малын тоо толгой нь тухайн өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлогч гол хүчин зүйл болно. Бүлгийн малчин өрхүүдийн малын тоог хонин толгойд шилжүүлснээр[9] чинээлэг 1000-1500, дундаж 150-5000, эмзэг 150-250, нэн эмзэг өрхүүд 70-50 малтай байна. Тооны хувьд хамгийн их нь хонь, дараа нь ямаа, адуу, үхэр орж байна.Чинээлэг өрхүүдийн хувьд дундаж бүлгийнхнээсээ (дунд орлоготой бүлэг) бараг хоёр дахин илүү тооны малтай. Заримэмзэг малчид нь чинээлэг малчдад "туслах малчнаар" ажиллаж ажлын хөлсөндөөсар бүр цалин авдаг бөгөөд тухайн өрхөө даган өөрийн цөөхөн малтайгаа нүүдэллэн явдаг. Зарим нь цалингаа бэлэн мөнгөөр авдаг бол зарим нь өөрсдийн хэрэгцээний зүйлсийг авах гэх мэт мөнгөн бус хэлбэрээр цалинждаг байна.

Үнэ төлбөргүй өмчлүүлэх 0.07 га газрыг хүн бүхэн авах боломжтой бөгөөд энэ талаар нутгийн захиргаанд бүртгүүлэн өргөдөл гаргаж холбогдох гэрээ байгуулан эзэмших эрхтэй болдог. Нэн ядуу өрхүүд нь энэхүү боломжийг бага ашиглаж буй нь судалгаагаар тогтоогдсон. Бүх өрхүүд наад зах нь 1 нарын батарей, 1 мотоциклтой. Зарим чинээлэг, дунд орлоготой өрхүүд нь жижиг ачааны машин эсвэл трактортой тул зах зээлд хүрэх боломжийг нь хялбар болгодог байна.

Өрхийн ам бүлийн тооны хувьд ерөнхийдөө цөөн (3-5), гэхдээ нэн эмзэг өрхүүдийн хувьд арай илүү байна (4-6 хүнтэй). Ерөнхий боловсролын сургуульд бүх бүлгийн малчид хүүхдээ сургадаг бөгөөд бага болон дунд боловсрол үнэ төлбөргүй байдаг байна. Зарим чинээлэг өрхүүд хүүхдүүдээ дээд эсвэл мэргэжлийн сургуульд сургадаг. Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийн хүртээмжийн хувьд бүхий л бүлэг ижилхэн. Ядуу өрхүүд нь эрүүл мэндийн даатгалгүй байв.

9 Нэг үхрийг таван хонин толгойд, адууг долоон хонин толгой, тэмээг зургаан хонин толгойд шилжүүлэн тооцох бол нэг ямааг 0.9 хонин толгой гэж үзнэ.

Хоол хүнсний эх үүсвэрүүд

Зүүн талд буй график нь өрхүүдийн хоол хүнсний эх үүсвэрүүдийг бүлэг бүрээр нь, 2016 оны зургаадугаар сараас 2017 оны тавдугаар сарыг хүртэлх хугацааг хамруулан харуулсан. Зүүн талд буй график өрхүүдийн хоол хүнсний эх үүсвэрийг 2016 оны зургаан сараас 2017 оны тавдугаар сарыг хамруулан харуулсан. Зургаа дугаар сар нь сүү, саалийн цаг эхэлж, хавар цагийн төгсгөл болдог тул хэрэглээний жилийн эхлэл хэмээн тооцогдоно. Хүнсний хэрэглээний хувьд 12 сарын хугацаанд нэг хүн өдөрт 2100 килокалорийн илчлэг аваахаар тооцон харуулав. Судалгаанд хамаарах тоон үзүүлэлт нь дээд болон доод хэмжээний дунджаар байгаа болно.



Зураг 8: Бүс 02 Хүнсний эх үүсвэрүүд

Малчин өрхүүдийн малын тоо олон (эд хөрөнгө) байх тусам өөрийн үйлдвэрлэдэг мал аж ахуйн бүтээгдэхүүний хүртээмж даган нэмэгдэж байна. Жилийн хүнсний хэрэгцээнд мал аж ахуйн бүтээгдэхүүний оруулах хувь нэмэр нь нэн эмзэг өрхүүдийн хувьд 25- 30%, чинээлэгт 60 гаруй хувь байна. Зуны улиралд хамгийн түгээмэл бүтээгдэхүүн нь сүү бөгөөд төрөл бүрийн цагаан идээ хийн хадгалах замаар бүтэн жилийн туршид хэрэглэдэг. Малын махыг шинээр нь эсвэл хөлдөөх, борцлох зэргээр хадгалж жилийн туршид хүнсэндээ хэрэглэж байна.

Бүсийн өрхүүдийн хувьд хүнсний хэрэгцээнд шаардлагатай бусад зүйлсээ зах зээлээс худалдан авдаг. Их хэмжээгээр худалдан авдаг гол хүнсний бүтээгдэхүүнд гурил орох ба бусад зүйлийн тоонд будаа, элсэн чихэр, ургамлын тос, гоймон, төмс, хүнсний ногоо (сонгино, байцаа, манжин, лууван) байна. Бүх өрхийн ам бүлийн бага ангийн хүүхэд нь сургуулийн үдийн цайнаас шаардлагатай илчлэгийнхээ багахан

хувийг авдаг. Цөөн тооны эмзэг өрхүүд сар тутамд нэг хүүхдэд 6,500 төгрөгийн, насанд хүрсэн нэг хүнд 13,000 төгрөгийн үнэ бүхий хүнсний талон авдаг.

Мөнгөн орлогын эх үүсвэрүүд



Зураг 9: Бүс 02 Мөнгөн орлогын эх үүсвэрүүд

Дээрх үзүүлсэн графикийн зүүн хэсэгт жилийн нийт мөнгөн орлогыг задлан, хувь хэмжээгээр нь нарийвчлан харуулсан. Баруун талд буй график нь нийт орлогыг төгрөгөөр, орлогын эх үүсвэрээр нь 2016 оны 6 дугаар сараас 2017 оны 5 дугаар сарыг дуустал хэрэглээний жилийн хугацаагаар харуулсан. Доод хэсэгт буй график нь дээрхийн адил мэдээллийг банкны зээлээр олсон мөнгөн орлогыг хасан харуулсан. Эдгээрийг доод хэсэгт буй зардлын хоёр дахь графиктай (зээлийн цэвэр үндсэн төлбөрийг багтаасан) харьцуулан үзэх боломжтой юм. Чинээлэг өрхүүд нь нэн ядуу өрхтэй харьцуулбал тухайн судалгааны жилд 4 дахин их мөнгөн орлого төвлөрүүлсэн байна.

ӨРХИЙН ОРЛОГО (ТӨГРӨГӨӨР)				
Бүлэг	**Нэн ядуу**	**Ядуу**	**Дунд орлоготой**	**Чинээлэг**
Өрхийн жилийн орлого	3,000,000-4,000,000	6,000,000-8,000,000	8,000,000-14,000,000	15,000,000-25,000,000

Хүснэгт 7: Бүс 02 Өрхийн орлого

Өрхийн орлогод мал, мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын эзлэх хувь нь нэн ядуу өрхийн нийт орлогын 40-50%, харин чинээлэг өрхийн орлогын 90 гаруй хувийг эзэлж байна (зээлийг оруулалгүй тооцоход). Үхрийн худалдаа нь бүх бүлгүүд дээр нийт амьд малын худалдааны хамгийн том хэсгийг бүрдүүлж буй ч хонь, ямаа, адууны борлуулалт мөн багагүй хувь хэмжээнд байна. Мал аж ахуйн бүхий л бүтээгдэхүүн дунд ноолуурын борлуулалт нь хамгийн гол орлогын эх үүсвэр болжээ.

Ядуу, нэн ядуу өрхүүд нь зөвхөн мал аж ахуйн орлогоор амьдрахад өрхийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй тул дутагдаж буй орлогоо туслах малчнаар ажиллах (жилийн туршид), хонь ноослох (7-8 дугаар сард), ямаа самнах (3-4 дүгээр саруудад)

зэрэг ажил хийж байна. Ийм төрлийн ажил олгогчид нь чинээлэг малчид байдаг.

Мал аж ахуйн орлого нь улирлын шинжтэй, олон тооны малтай өрхүүд (ядуу, дунд, чинээлэг бүлгийн) хамгийн өндөр зардалтай саруудад банкнаас зээл авах боломжтой. Нэг удаад нэг л төрлийн зээл авах боломжтой бөгөөд эргэн төлөлтийн хугацаа нь үндсэндээ 1 жил байна. Жилийн хүү нь 21%. Ихэнх нэн ядуу өрхүүд зээл авдаггүй ч хэрэгцээт зүйлсээ дэлгүүрээс зээлээр худалдан авах байдлаар гол хэрэгцээгээ хангаж байна. Энэ тохиолдолд хүү тооцохгүй, гэхдээ зээлээр олгох барааны хэмжээ хязгаартай байдаг.

Төрөөс олгох нийгмийн халамж дэмжлэг нь үндсэн хоёр механизмаар дамжин хэрэгждэг. Эдгээрийн эхнийх нь 18 хүртэлх насны хүүхэд бүрт олгодог сар бүрийн 20,000 төгрөг байна. Хүүхдийн мөнгийг 2018 оны 1 дүгээр сарыг хүртэл бүх хүүхдэд олгож байсан ч түүнээс хойш өрхийн орлогоос хамааран олгох болсон. Түүнчлэн боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлсэн хонины ноосны урамшуулалд килограмм тутамд 1,000 төгрөг олгох замаар төрөөс дотоодын боловсруулах үйлдвэрүүдийг дэмждэг.



Зураг 10: Бүс 02 мөнгөн орлогын эх үүсвэрүүд– банкны зээлийн эргэн төлөлтийг хассан

Зардал



Зураг 11: Бүс 02 Зардлын хэв шинж

Дээрхи график нь тухайн судалгааны жилийн зарцуулалтын хэв шинжийг харуулж буй бөгөөд хугацааны хувьд 2016 оны 6 сараас 2017 оны 5 дугаар сарыг хамарна. Хөрөнгийн хэмжээнээс хамааран абсолют зардал нь нэмэгдэж буйн зэрэгцээ график дээр харуулсан зарцуулалтын задаргаа нь төрөл бүрийн ангилал дээрх зарцуулсан орлогын дүнг харьцангуй утгаар нь харуулж байна.

Зээлийн эргэн төлөлтийг графикийн зүүн хэсэгт багтаан оруулсан (бүтэн дүнгээр) ба доорх график дээр цэвэр төлөх дүнгээр нь харуулсан.

Малчин өрхүүдийн худалдан авдаг гол хүнсний бараа нь гурил, будаа, элсэн чихэр, ургамлын тос, гоймон, хүнсний ногоо болон төмс юм. Хоол хүнсний зүйл, түүнчлэн бусад өрхийн хэрэглээний зүйлсэд зориулан зарцуулж буй нийт хувь хэмжээ нь эд хөрөнгийн хэмжээг даган буурч байна. “Өрхийн хэрэгцээт зүйл” хэмээх ангилалд цай, давс, саван, түлш болон гэр ахуйн хэрэгсэл багтана. Өрхийн хэрэгцээт зүйл, утасны зардал, хувцас, нийгмийн үйлчилгээнд зарцуулсан абсолют дүн нь эд малын тоо болон өрхийн орлогоос хамааран их бага байна. “Нийгмийн үйлчилгээ” гэдэгт боловсрол, эрүүл мэндийн зардлыг багтаав.



Зураг 12: Бүс 02 Зардлын хэв шинж, цэвэр зээл эргэн төлөлтийн хамтаар

Зардлын томоохон ангилалын зарлагын хувь хэмжээ нь бусад ангилалаас ялгаатай нь өрхийн амьжиргааны түвшингээс хамааран өсөж байна. Үүнд мал аж ахуйд зарцуулсан зардал, малын эм, хужир давс, тэжээл, ажилчин авч мал маллуулах, хашаа хороо барих болон тээврийн зардлуудыг багтаана.

"Бусад" хэмээх ангилалд согтууруулах ундаа, гоо сайхны хэрэгсэл худалдан авах зардал болон хадгаламжийг багтаадаг. Энэхүү үлдсэн мөнгөн дүн нь өрхийн орлогоос хамааран өсөж байдаг.

Мал сүргийн шилжилт нүүдэл

Сүхбаатар аймгийн тал хээрийн, мал аж ахуйн амьжиргааны бүсийн хэмжээнд хамаарах малчин өрхүүд жилдээ дөрвөн удаа нүүдэг ба өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа нь хоорондоо 20-30 км зайтай байдаг. Судалгааны жилийн хугацаанд ихэнх өрхүүд малаа авч нүүсэн байна. Үүнд уналгын мал, эм мал, хөхүүл мал болон төл мал ч мөн багтана. Малын сүргийн гуравны нэг нь нас гүйцсэн эм мал байдаг бөгөөд энэ нь бүх бүлэг дээр бараг ижил байна. Бүх төрлийн малын төллөлт, борлуулалт, хорогдол болон нүүдлийн хэв шинж нь энэхүү бүсийн хувьд тухайн жилд хэвийн байв.

Малчдын зуслан ихэнхдээ сумын төвийн ойролцоо эсвэл усны эх үүсвэрийн ойролцоо байдаг. Харин өвөлжөө нь уул, толгодод ойр, сумын төвөөс харьцангуй хол салхины нөмөр газарт нутагладаг. Зуслан болон өвөлжөөний дунд хаваржаа,намаржаа байрлана. Хавар хүчтэй салхилдаг тул, өвөл ядарч сульдсан малыг салхины нөмөртэй газар нутаглах шаардлагатай бөгөөд харин намар нөмөрлөх шаардлага бараг үгүй.

Малчид нүүхдээ 3 дугаар сард хаваржаандаа, 6 сард зусландаа, 9 сард намаржаандаа, 11 сарын сүүл, 12 сарын эхээр өвөлжөөндөө тус тус буудаг. Үндсэндээ нэг газарт нэг эсвэл хоёр гэрээрээ буух ба эс бөгөөс нэг доор хэт олон тооны мал бөөгнөрөх аюултай. Сургуулийн насны хүүхэдтэй өрхүүд заримдаа тусдаа буюу ээж нь хүүхэдтэйгээ сумын төв дээр, бусад нь хөдөө мал дээрээ амьдрах нь түгээмэл ажиглагдаж байлаа.

Өвөл цаг хүндрэх үед малаа оторлон 150 хүртэл км зайд нүүх тохиолдол байх ба энэ үед зөвхөн эрчүүд оторт явж, өрхийн бусад хүмүүс нь ядарч сульдсан малтайгаа (өвчтэй, хээлтэй, төл мал, хөгшин мал) өвөлжөөндөө үлддэг байна.

Хариу арга хэмжээний стратеги

Ямар нэгэн байгалийн гамшиг тохиох эсвэл мал аж ахуйн үйлдвэрлэл тааруу байх жилд малчин өрхүүд нь хэд хэдэн стратегийг ашиглан хүнсний болон мөнгөн орлогын хэрэгцээгээ хангахыг хичээдэг байна. Үүнд:

- Бүр өрхүүд юуны өмнө чухал шаардлагатай биш бараа болон үнэ өндөртэй зүйлсийг **худалдан авах зардлаа бууруулдаг**, жишээ худалдан авах будааны хэмжээг багасгах, эсвэл баяр ёслол, согтуурулах ундаа, хувцас зэргийг худалдан авах зардлаа танаж оронд нь хямд үнэтэй гурил худалдан авах гэх мэт.
- Нэн ядуу болон ядуу өрхүүд нь олон малтай өрхөд туслах, тэдэнтэй хамт амьдарч, **мал аж ахуйн салбарт хөдөлмөр эрхлэх** замаар өөрсдийн мөнгөн орлогоо нэмэгдүүлэх арга хэмжээ авдаг байна. Зарим хүндрэлтэй нөхцөл байдлийн хувьд тааруу жилүүдэд мал ау ахуйгаас хамааралтай ажил олоход хүндрэлтэй болдог тул зарим хүмүүс хот суурин газар руу нүүхээс өөр сонголтгүй болдог байна.
- Бүх бүлгийн малчин өрхүүд өрхийн мөнгөн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор, **амьд мал зарж борлуулахаа нэмэгдүүлэх**, мөн зуд болох шинж тэмдэг үүссэн нөхцөлд малын тоогоо бууруулах арга хэмжээг авдаг. Гэхдээ цаг хүндрэх үед малын үнэ буурч, энэхүү стратегийн үр дүнтэй байдлыг хязгаарладаг байна.
- Тохиож болох зудын бэлтгэл болгон өрхүүд нь **нэмэлт өвс, тэжээл худалдан авч**, хашаа хороогоо засаж сайжруулах, шаардлагатай бол цас багатай газарт отроор нүүдэг.

Гол үзүүлэлтүүд

Доорх хүснэгтэд *Сүхбаатар аймгийн тал хээрийн мал аж ахуйн амьжиргааны бүсийн* өрхийн эдийн засагт томоохон хувь нэмэр оруулдаг хүнсний болон бусад орлогын эх үүсвэрүүдийн гол үзүүлэлтүүдийг харуулав. Эдгээр үзүүлэлтүүд нь орон нутгийн эдийн засагт оруулж буй ашиг болон алдагдлыг хянах ба үүнийг цаашид байнгын хяналтын систем болон эсвэл тодорхой хугацаанд үнэлгээ хийх замаар хянах боломжтой.

Зүйлс	**Гол үзүүлэлт-Тоо хэмжээ**	**Гол үзүүлэлт-Үнэ**
Мал аж ахуйн үйлдвэрлэл	• • Үхрийн тоо • Адууны тоо • Ямааны тоо • Хонины тоо • Сүү (мал төллөх хувь хэмжээ, сүүний гарц) • Малын мах • Ноолуур • Ноос • Мал аж ахуйтай холбоотой боломжит ажил	• Үхрийн үнэ • Адууны үнэ • Ямааны үнэ • Хонины үнэ • Ноолуурын үнэ • Ноосны үнэ • Мал маллах ажлын хөлсний хэмжээ • Арьс, ширний үнэ
Хүнс, мөнгөн орлогын бусад эх үүсвэр	• Нийгмийн халамж • Зээл олдох боломж	• Нийгмийн халамжийн дүн • Зээлийн зардал

Хүснэгт 8: Бүс 02 Гол үзүүлэлтүүд

Хөтөлбөрийн үзүүлэх нөлөөлөл

Хөтөлбөрийн зүгээс судагаанд хамрагдсан хүмүүсийн өөрсдийн гаргасан шийдэл, санал, судалгааны багийн орон нутагт хийсэн ажиглалт, хэлэлцүүлгийн хүрээнд гаргасан санал шийдвэрүүдийг тусган дараах дүгнэлтийг хүргэж байна. Эдгээр санал дүгнэлтэд үндэслэн цаашид боломжит судалгааг (feasibility study) хийх шаардлагатай.

- Бэлчээрийн доройтол улам нэмэгдэж байгаатай холбогдуулан малын тоо толгойтой уялдуулан бэлчээр ашиглалтын татвар, хураамж ноогдуулах боломжит шийдлүүдийг судлан үзэх шаардлатай. Мөн 1990 оноос өмнө малын хөлийн татвар авч байсан нь бэлчээрийн даац хэтрэхээс сэргийлж байсан байна.
- Шүлхий, хонины цэцэг зэрэг малын халдварт өвчин нь тухайн амьжиргааны бүсэд байнгын асуудал үүсгэж, малын хорогдлыг нэмэгдүүлж, мал махны борлуулалтыг хязгаарлаж байна. Энэ нь цаашид мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах шаардлагатайг харуулж байна.
- Амьжиргааны энэ бүсэд малчид зөвхөн үнээгээ саадаг төдийгүй бусад төрлийн малыг саах мөн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулан борлуулах боломжтой байна. Энэ бүсэд одоогоор сүүн бүтээгдэхүүнийг Монголын бусад аймгуудаас авчран аймгийн зах дээр худалдаалдаг байна.
- Малын хорогдлоос сэргийлэхийн тулд малын хашаа, хороог сайжруулах арга замыг судлан үзэх шаардлагатай.
- Малчдын орлогын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх, зах зээлийн чиглэлийн үйл ажиллагаатай хамтруулан малчдын зах зээлийн холбоосыг сайжруулах чиглэлээр судлах.
- Амьжиргааны энэхүү бүсэд зудын аюул тулгарахад эрт үеийн арга хэмжээ нь ядуу өрхүүдэд шаардлагатай хоол хүнсний зүйл болон бусад шаардлагатай эд зүйлийг өвөл эхлэхээс өмнө нөөцлөхөд анхаарах чиглэлийн үйл ажиллагаа зохион байгуулах зэрэг байж болно.

3. 2017-2018 болон 2018-2019 онуудын Монгол улсын нөхцөл байдлын дүн шинжилгээ: Хоёр аймгийн орон нутгийн амьжиргааны бүс

2018 оны 1 дүгээр сар

Энэхүү бүлэгт 2018 оны 1 дүгээр сард, Монгол улсын хоёр аймгийн амьжиргааны бүсийн Өрхийн эдийн засгийн шинжилгээний хүрээнд гүйцэтгэсэн Үр дүнгийн шинжилгээний баримт бичигт суурилсан судалгааны үндсэн үр дүнгүүдийг тусган харуулсан. Үр дүнгийн шинжилгээний сургалтын хүрээнд ПИН байгууллага тус судалгааны нөхцөл байдлын дүн шинжилгээг хийж гүйцэтгэв. Тус арга хэмжээ нь сургалт, шинжилгээний хэсгүүдээс бүрдсэн юм. Гол зорилго нь Өрхийн эдийн засгийн шинжилгээг ашиглан 2017-2018 болон 2018-2019 онуудын хоёр бүсийн өрхийн эдийн засгийн нөхцөл байдлыг таамаглан гаргахад оршино. Улмаар дүн шинжилгээний хүрээнд цуглуулсан мэдээлэл нь Сүхбаатар, Архангай аймгууд дахь зудад нэрвэгдсэн ядуу малчин өрхүүдийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор зохистой хүнсний баталгаат байдал/амьжиргааг дэмжих үйл ажиллагааг төлөвлөн явуулахад ашиглагдах юм.

Өрхийн эдийн засгийн үнэлгээний арга зүй болон Монгол улсын амьжиргааны суурь мэдээлэл

Энэхүү арга зүй нь ирэх саруудын хугацаанд хомсдолтой нүүр тулж болох болон эдгээр хомсдолын цар хүрээ, хугацааг Эдийн засгийн шинжилгээгээр тодорхойлон гаргах боломжтой. Энэ талаар тус бүлэгт товч дурдав[10].

Өрхийн эдийн засгийн шинжилгээнд суурилсан тухайн жилийн үнэлгээг хоёр төрлийн мэдээллийг нэгтгэх замаар гаргадаг:	
Амьжиргааны суурь мэдээлэл+Мониторинг/Улирлын → үнэлгээний мэдээлэл *(нөхцөл байдал) (өөрчлөлт)*	Таамагласан нөхцөл байдал, үйл ажиллагааны хэрэгцээний шинжилгээ *(үр дүн)*

Зураг 13: Өрхийн эдийн засгийн үнэлгээний арга зүй

10 Өрхийн эдийн засгийн шинжилгээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү баримт бичгээс үзэж болно: http://foodeconomy.com/wp-content/uploads/2015/09/HEA-Guide-for-Programme-Policy-Makers.pdf.

Амьжиргааны суурь мэдээлэл (Нөхцөл байдал)

Өрхийн эдийн засгийн шинжилгээний суурь мэдээллийг газар зүйн бүсээр нь (амьжиргааны ерөнхий бүсээр) болон малчны бүлгүүдийн байдлаар (малчдын амьжиргааны түвшингийн бүлгээр) нь нэгтгэн харуулав. Ингэхийн учир нь хүмүүсийн хүнсний бүтээгдэхүүн болон мөнгөн орлогын хүртээмж, шаардлагатай зардлууд нь тухайн хүн хаана амьдарч буй болон амжьжиргааны түвшингээс нь хамааралтай байдагт оршино.

Үндсэндээ Өрхийн эдийн засгийн шинжилгээний амьжиргааны суурь мэдээлэл бэлтгэх анхны алхам нь амьжиргааны бүсийн зургийг гаргаснаар эхэлдэг. Монгол улсын хувьд үндэсний хэмжээний амьжиргааны бүсийг тодорхойлон гаргаагүй тул энэхүү үе шатыг хийлгүй алгассан. Орон нутагт ажилласан ажлын хүрээнд хоёр аймагт (Сүхбаатар, Архангай) хийсэн хэлэлцүүлгээр хоёр амьжиргааны бүсийг тогтоон гаргасан: Үүнд Архангай аймгийн өндөр уулын бүсийн мал аж ахуйн амьжиргааны бүс болон Сүхбаатар аймгийн тал хээрийн мал аж ахуйн амьжиргааны бүсүүд байна. Хоёр дахь бүс нь Сүхбаатар аймгийн гол амьжиргааны бүс бөгөөд тус аймгийн хил хязгаарыг даван үргэлжилж ч болох юм. Эхний бүс нь Архангай аймаг дахь амьжиргааны хоёр үндсэн бүсийн нэг бөгөөд зарим талаар өөрийн аймгийн хил хязгаараар ч хязгаарлагдахгүй байж болно. Эдгээр хоёр аймагт суурь мэдээлэл цуглуулах судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн[11].

Өрхийн эдийн засгийн шинжилгээний суурь үнэлгээний дараагийн үе шат нь амьжиргааны бүсээр нь ялган бүлгүүдийг амьжиргааны түвшнээр нь хуваах үйл ажиллагаа юм. Бүлгүүдийг амьжиргааны түвшнээр нь задлан хуваахдаа тухайн орчинд хэрэглэдэг тодорхойлолтыг ашиглан, хөрөнгийн хэмжээг нь (газар, мал, өрхийн хэмжээ, ур чадвар гэх мэт) тоон үзүүлэлтээр гаргав. Монгол улс дахь амьжиргааны энэхүү хоёр бүсэд бүлгүүдийн амьжиргааг үндсэндээ малын тооноос нь хамааран ангилав.

Суурь үнэлгээний гуравдугаар үе шат нь хоол хүнс, орлого болон зардлын бүхий л эх үүсвэрийг тоон үзүүлэлтээр, бүлэг нэг бүрээр гаргах ба үүнийг "судалгааны жилийн" хэмжээнд тогтоодог. "Судалгааны жил" нь бүс бүрээр ялгаатай, өрхийн хэмжээний үйлдвэрлэл эхлэх сараас эхлэн тооцож, хоол хүнсний дутагдалтай улирал дуусах хугацаа хүртэл үргэлжилнэ. Хоёр бүс дээр судалгааны жилийг сонгохдоо дундаж жилийг сонгон авсан.

Дараах хүснэгт дээр 2018 оны 1 дүгээр сард хийсэн Үр дүнгийн шинжилгээнд багтсан амьжиргааны хоёр бүсийн ерөнхий шинжүүдийг тоймлон харуулав.

11 Архангай аймгийн өндөр уулын бүсийн мал аж ахуйн амьжиргааны бүлгийн орон нутаг дахь хээрийн судалгааны ажлыг Ихтамир, Чулуут, Тариат, Хангай, Цахир, Өндөр-Улаан, Булган болон Цэнхэр сумдад, Сүхбаатар аймгийн тал хээрийн бүсийн мал аж ахуйн амьжиргааны бүхий орон нутаг дахь судалгааг Халзан, Дарьганга, Онгон, Буяндэлгэр, Уулбаян, Асгат, Мөнххаан, Түмэнцогт сумдад хийж гүйцэтгэсэн.

<table>
<tr><th colspan="3">Бүс 01: Архангай аймгийн өндөр уулын бүсийн мал аж ахуйн амьжиргааны бүс</th></tr>
<tr><td>Мал</td><td>Сарлаг
Адуу
Ямаа
Хонь
Ноолуур
Ноос
Сарлагийн сүү
Мах
Мах борлуулсны орлого
Мал аж ахуйн салбарт ажил эрхлэх</td><td rowspan="2">Архангай аймгийн өндөр уулын, мал аж ахуйн амьжиргааны бүс нь үндсэндээ Архангай аймгийн баруун хэсгийг хамран оршдог. Тухайн бүс нь уур амьсгалын хувьд Баруун Монгол болон Хангайн нурууг даган байрших туйлын дэд бүсийн уур амьсгалтай. Тухайн бүс нь мөн хагас цөлжсөн, ойт-хээрийн бүс, дов толгодоор бүрхэгдсэн.

Амьжиргааны энэхүү бүсийн эдийн засаг нь мал аж ахуй, мал аж ахуйн бүтээгдэхүүнд суурилдаг. Сарлаг, адуу, хонь, ямаа голлон өсгөдөг. Амьд мал, малын гаралтай бүтээгдэхүүн болох сүү, ааруул, шар тос, тараг, айраг, ноос, ноолуур зэрэг бүтээгдэхүүн эдийн засгийн үндэс болж байна. Амьд малын зах зээл дээр сарлаг, адуу нь хамгийн өндөр үнэлгээтэй бол ноолуур нь хамгийн өндөр үнэлэгддэг мал аж ахуйн бүтээгдэхүүн байна. Дотоодын боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн тохиолдолд малчид нөхөн олговор авдаг ба энэ нь өөр бусад орлого олох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмждэг байна.

Бүх бүлгийн хувьд нийт орлогынх нь хамгийн багадаа гурваны нэг нь мал аж ахуй, мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтаас бүрэн хамааралтай байдаг. Амьжиргаа доогуур бүлэг нь мал хариулах, хонь ноослох, хүнсний бүтээгдэхүүн зарж борлуулах, түлшний мод бэлтгэж зарах зэргээр мал аж ахуйгаас олох орлогодоо нэмэр болгодог.</td></tr>
<tr><td>Орлогын бусад эх үүсвэрүүд</td><td>Төрөөс олгох нийгмийн халамж
Зээл</td></tr>
</table>

Хүснэгт 9: Бүс 01 Өрхийн эдийн засгийн шинжилгээний суурь мэдээллийн тойм

Бүс 02: Сүхбаатар аймгийн тал хээрийн бүсийн мал аж ахуйн амьжиргааны бүс		
Мал	Үхэр Адуу Ямаа Хонь Ноолуур Ноос Үхрийн сүү Мах Мал аж ахуйн салбарт ажил эрхлэх	*Сүхбаатар аймгийн тал хээрийн мал аж ахуйн амьжиргааны бүс* нь Монгол орны зүүн хэсгийн Сүхбаатар аймгийг хамран оршино. Тухайн бүс нь хагас цөлөрхөг бүс бөгөөд, цаг уурын хувьд хуурай, өргөн уудам тэгш, өвст тал бүхий онцлогтой. Амьжиргааны энэ бүсийн хүн ам нь үндсэндээ нүүдэлч малчдаас бүрддэг. Бүсийн үндсэн амьжиргаа мал аж ахуйд суурилах ба хонь, ямаа, үхэр, адуу, мөн цөөн тооны тэмээ өсгөн үржүүлж байна. Тухайн бүс нь адуу голлон өсгөдөг, хурдан удмын адуутай гэж тооцогддог тул Монгол орны бүхий л нутгаас хүмүүс ирж хурдны морь худалдан авдаг. Мал аж ахуйн салбар нь бэлчээрийн маллагаатай, нийтийн эзэмшлийн бэлчээрт бүтэн жилийн туршид малаа бэлчээдэг.
Орлогын бусад эх үүсвэрүүд	Төрөөс олгох нийгмийн халамж Зээл	Бүх төрлийн малыг зарж борлуулдаг. Мал аж ахуйн гол бүтээгдэхүүн нь Баяндэлгэрийн улаан ямааны сайн чанарын ноолуур. Ноос болон арьс шир нь мал аж ахуйн хоёрдогч бүтээгдэхүүн. Үхрийн сүү, сүүн бүтэгдэхүүнийг өрхийн хэрэгцээнд ашиглахын зэрэгцээ мөн зарж борлуулдаг. Үнээнээс бусад төрлийн малыг саадаггүй. Мал тарга хүч сайн авсан, эрэлт өндөр зун, намрын улиралд амьд мал голлон борлуулдаг бөгөөд энэ үеэр ч малчдын бэлэн мөнгөний хэрэгцээ өндөр байдаг ажээ. 3-4 дүгээр сард ноолуур, 6-8 дугаар саруудад ноосоо борлуулдаг. Өвлийн улиралд мал аж ахуйгаас орлох орлого буурч, маш бага хэмжээнд хүрдэг. Амьжиргаа доогуур өрхүүд мал ихтэй айлуудын хонь ноослох, мал маллах ажил хийх зэргээр орлого олдог.

Хүснэгт 10: Бүс 02 Өрхийн эдийн засгийн шинжилгээний суурь мэдээллийн тойм

Өрхийн эдийн засгийн үнэлгээний суурь мэдээлэл нь энэхүү Үр дүнгийн шинжилгээнд шаардлагатай үндсэн мэдээллийг хангаж, үйлдвэрлэл, үнийн өөрчлөлтөөс үүдэх гол нөлөөллийг үнэлэн үзэх нөхцөлийг тодорхойлсон байдаг.

Мониторингийн мэдээллээс асуудлын тодорхойлолтыг боловсруулах нь (Өөрчлөлтүүд)

"Асуудлуудыг тодорхойлолт" гэдэг нь үндсэндээ өрхийн түвшинд эдийн засгийн үр дагавар үзүүлж буй шок эсвэл бусад өөрчлөлтүүдийг тодорхойлон гаргах явдал юм. Ингэснээр тухайн өөрчлөлтүүдийг (эерэг болон сөрөг) математик аргаар өрхийн стратеги нэг бүртэй нь холбон өгдөг. Асуудлын тодорхойлолтыг боловсруулах үйл явц нь гарч буй бүх төрлийн өөрчлөлтөөс хүнс, орлого, зарлагад үзүүлж буй нөлөөлөл нэг бүрийг нарийвчлан судлах чухал ач холбогдолтой үйл ажиллагаа юм. Тухайн эх үүсвэрүүд нь олон тоотой байж болох ч ач холбогдлын хувьд ялгаатай тул бүлэг, амьжиргааны бүс бүрт хамаарах гол эх үүсвэрийг олж тогтоох нь чухал байдаг. Гол эх үүсвэрийг нь (гол үзүүлэлт) энд нийт хүнс эсвэл мөнгөн орлогод[12] томоохон нөлөө бүхий хэмээн тодорхойлж, тухайн гол эх үүсвэрийн хэмжээ буурснаар хүртээмжид томоохон нөлөө үзүүлдэг болохыг нь тооцон гаргасан. Хүснэгт 2 дээр амьжиргааны хоёр бүсийн гол үзүүлэлтүүдийг тухайн хамаарах оны хүнс тэжээлийн эх үүсвэр, орлогын эх үүсвэр болон зардлын хэв шинж дээр нь үндэслэн тоймлон харуулсан.

Хүснэгт 11: Гол үзүүлэлтүүд		
	Бүс 01: Архангай	**Бүс 02: Сүхбаатар**
Орлогын эх үүсвэрт хамаарах тоо хэмжээ:	Сарлаг Адуу Ямаа Хонь Сарлагийн сүү Ноолуур Сарлагийн хөөвөр Ноос Мах Бусдаас өгсөн мал, мах Мал аж ахуйн салбарт ажил эрхлэх Нийгмийн халамж	Үхэр Адуу Ямаа Хонь Үнээний сүү Ноолуур Ноос Мах Арьс, шир Мал аж ахуйн салбарт ажил эрхлэх Нийгмийн халамж
Орлогын эх үүсвэрт хамаарах үнэ:	Сарлаг Адуу Ямаа Хонь Сарлагийн сүүн бүтээгдэхүүн Ноолуур Сарлагийн хөөвөр Ноос Мал аж ахуйн салбарт ажил эрхлэх Нийгмийн халамж	Үхэр Адуу Ямаа Хонь Ноолуур Ноос Арьс, шир Мал аж ахуйн салбарт ажил эрхлэх Нийгмийн халамж
Зардалд хамаарах үнэ:	Гурил Малын эм Давс, хужир Тээвэр Малын тэжээл, хашаа хороо Хүн ажиллуулах (мал аж ахуйд) Зээлийн төлбөр Боловсрол Эрүүл мэнд Утасны нэгж	Гурил Малын эм Давс, хужир Тээвэр Малын тэжээл, хашаа хороо Хүн ажиллуулах (мал аж ахуйд) Зээлийн төлбөр Боловсрол Эрүүл мэнд Утасны нэгж

Хүснэгт 11: Бүс 01 болон 02-ын голлох үзүүлэлтүүд

Монгол улсын хувьд ихэнх гол үзүүлэлтүүд дээр байнгын мониторинг хийж, асуудлуудын тодорхойлолтыг хялбархан боловсруулан гаргах боломжтой.

Таамаглах нөхцөл байдлын дүн шинжилгээ (Үр дүнгийн шинжилгээ)

Үр дүнгийн шинжилгээ нь өнөөгийн нөхцөл байдлаас мэдээлэл авах (мониторингийн мэдээлэл), энэхүү мэдээллийг тухайн хамаарах судалгааны жилийн мэдээлэлтэй уялдуулах (суурь мэдээлэл) замаар тухайн жилийн нийт орлогыг таамаглан гаргах үйл явц юм. Энэхүү үйл явцын хүрээнд нийт гурван төрлийн мэдээллийг нэгтгэн уялдуулдаг ба эдгээрт суурь хүртээмжийн мэдээлэл, тулгарах гамшгийн хүндрэл, хямралын мэдээлэл (жишээ нь энэ жилийн хүнс, орлогын хүртээмжид сөрөг нөлөөлөл үзүүлэх хүчин зүйлс, жишээ нь мал аж ахуйн үйлдвэрлэл, зах зээлийн үнэ) болон дасан зохицох стратегийн тухай мэдээлэл (жишээ нь хямрал, гамшигт өртөх тохиолдолд хүмүүсийн голлон анхаардаг орлого, хүнсний эх үүсвэр гэх мэт) багтана[13]. Энэхүү аргачлалыг: **Суурь + Аюул + Дасан зохицолт = Үр дүн** хэмээн тоймлон тодорхойлж болно.

Энэхүү нөхцөл байдалд дүн шинжилгээний зорилго нь тохилдох аюул, гамшгийн талаарх мэдээлэл, эдгээрээс үүдэн хоол хүнс, орлогод үзүүлэх нөлөөллийн тухай мэдээллийг гарган ашиглах явдал юм. Үр дүнгийн шинжилгээний гарц нь тогтоох аюулын нөлөөлөл, дасан зохицох стратегийн хүрээнд төвлөрүүлэх орлогыг харгалзан тухайн жилийн нийт хоол хүнс, орлогын тойм тооцоо хэлбэрээр гарна. Сөрөг эсвэл хор нөлөө үзүүлж болох дасан зохицох стратегийг (жишээ нь амьд мал зарж борлуулах тогтвортой бус түвшин гэх мэт) шинжилгээнд хамруулдаггүй.

Дараагийн үе шат нь тооцон гаргасан нийт орлогыг өмнө нь тогтоосон хоёр босго үзүүлэлттэй харьцуулан, ямар нэгэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага буй эсэхийг тогтоодог. Энэ талаар жишээн дээр суурилан дараах зураг дээр тайлбарласан. Тухайн хамаарах жилийн нийт хүнсний орлогыг зүүн талд тусгасан бол шинжилгээний хамрах жилийн нийт хүнсний орлогод хамаарах стратегийг багтаан баруун талын хэсэгт харуулсан. Улмаар эдгээр үзүүлэлтийг хоёр суурь утгатай харьцуулсан.

13 Дасан зохицох боломжит стратегийн тухай мэдээллийг суурь үнэлгээний хүрээнд цуглуулдаг.

Зураг 14: Өрхийн эдийн засгийн шинжилгээний хүрээ: Хялбаршуулсан дүрслэл



Суурь нөхцөл: Эхний багана нь тухайн хамаарах суурь лавлагаа жилийн хүнс, орлогын хүртээмжийг харуулж байна. Энэ нь шок нэрвэхээс өмнөх суурь нөхцөл байдал байна.

Дасан зохицох арга хэмжээ авахгүй бол асуудлын үзүүлэх нөлөөлөл: Хоёр дахь багана нь хөрш улсад ган болсноос үүдэн дотоодын зах зээлд ажиллах хүчин ихээр нэмэгдэн, ажлын цалин хөлс буурах зэрэг шок тохиоход хүртээмжид хэрхэн сөргөөр нөлөөлж буйг харуулсан.

Үр дүнгийн шинжилгээ: Гурав дахь багана нь тухайн өрхийн дасан зохицох стратегийн үр дүнд үүдсэн хүнс, орлогын хүртээмжийг харуулж байна. Энэ тохиолдолд тэрхүү дасан зохицох стратеги нь өмнөхөөс илүү олон тооны мал борлуулан хомсдолоо шийдэх стратеги байжээ.

Амьжиргааны босго: Хүнсний минимум хэрэгцээг 100% хангахад шаардлагатай орлого, нэмэх нь хүнсний бус шаардлагатай зүйлс[14].

Амьжиргааг хамгаалах/баталгаажих босго: Эрүүл мэнд, боловсрол, орц зэрэг нэмэлт зардлуудыг төлөхөд шаардлагатай орлого[15].

Зураг 14: Өрхийн эдийн засгийн шинжилгээний хүрээлэл–хялбаршуулсан зураглал

Нийт орлогын хэмжээ амьжиргааг хамгаалах босго хэмжээнээс доош орох тохиолдолд богино болон дунд хугацаандаа тэдний амьжиргааг тогтвортой хангах онцгой байдлын арга хэмжээг (иргэд шаардлагатай эрүүл мэнд, боловсрол, бусад хэрэгцээтэй зүйлсийг худалдан авах боломжийг хангах зорилгоор) авч хэрэгжүүлэх шаардлага үүснэ. Орлогын хэмжээ нь амьжиргааны босгоос доош ороход амьжиргааг тогтвортой хангах үйл ажиллагаанаас гадна шаардлагатай хүнс тэжээлийн дутагдлыг (2100 килокалори хүн/өдөр) нөхөх шаардлага гарч ирнэ. Иргэдийн амь насыг авран хамгаалахаас гадна тулгарах хомсдол, авах арга хэмжээний хэрэгцээ зэргийн өнөөгийн ач холбогдлыг амьжиргааны бус харин амьжиргааг хамгаалах босготой хамааруулан тооцдог.

14 Амьжиргааны босго нь хамгийн наад захын хүнсний хэрэгцээнээс арай дээгүүр хэмжээнд тогтоогдсон байдаг ба ингэснээр хүнсний бус бусад шаардлагатай зүйлсэд зардал гаргахыг тооцсон байдаг. Эдгээр нь хоол хүнс бэлтгэхэд шаардлагатай зүйлс (жишээ нь давс, саван, түлшний мод гэх мэт) болон хэрэглээний усан хангамжийн тухайн жилийн зардал зэргийг багтаадаг. Монгол улсын хувьд орон байр болон хувцасны зардлыгамьжиргааны босгод мөн хамруулдаг нь бусад улсаас ялгаатай бөгөөд гол шалтгаан нь маш хүйтэн цаг агаар байдаг.

15 'Амьжиргааг хамгаалах сагс' нь баялгийн бүлэг нэг бүрийн зүгээс мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжтэй орц, эрүүл мэнд, боловсролын зардлыг 100% багтаадаг. Бусад зүйлсийг (амьжиргааны стандартад хамаарах) ядуу өрхийн зүгээс тэдгээрт зарцуулах зардлын 25-100%-тай тэнцэх хэмжээнд (хүнсний бус зүйлс, үндсэн хэрэглээний зүйлс) тооцон оруулсан.

НӨХЦӨЛ БАЙДАЛ

Мал аж ахуйн үйлдвэрлэл, бараа бүтээгдэхүүний үнийн мониторингийн албан ёсны мэдээллийг ашиглан тухайн жилийн тулгарч болох асуудлыг тодорхойлон гаргасан. Дүн шинжилгээ хийгдсэн нөхцөл байдлын элемент нэг бүрийг доорх хэсэгт тайлбарласан ба эдгээр элементүүдэд цаашид мониторинг хийж, нэмэлт мэдээлэл цуглуулсан тохиолдолд шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулах боломжтой.

Өнөөгийн хэрэглээний хугацаанд (жил) сөрөг нөлөө үзүүлж буй гол хүчин зүйл нь зун тохиох ган, өвлийн их цас, хүйтэн цаг ууртай хавсран үүсэж, мал олон тоогоор хорогдоход хүргэх *зуд* юм. Сүхбаатар аймгийн хувьд энэхүү үзэгдэл нь 2017 онд тус аймагт гарч, хорио цээр тогтоон, мал, амьтны худалдаанд хориг тавихад хүргэсэн малын шүлхий өвчинтэй хавсран сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

Хоёр хугацааг тус тусад нь шинжлэн үзсэн ба эдгээр нь: 1) энэ жил (2017 оны 6 дугаар сараас 2018 оны 5 дугаар сар) буюу зун ган болж, өвөл зуд залгасан хугацаа; болон 2) дараа жил (2018 оны 6 дугаар сараас 2019 оны 5 дугаар сар) буюу малын хорогдлоос үүдэх гол нөлөөлөл мэдрэгдэж эхлэх хугацаа юм.

Хүснэгт 12: Энэ жилийн нөхцөл байдал			
Амьжиргааны бүс	Хамаарах судалгааны жил	Энэ жил	Ирэх жил
Бүс 1	2015 оны 6 сараас 2016 оны 5 сар	2017 оны 6 сараас 2018 оны 5 сар	2018 оны 6 сараас 2019 оны 5 сар
Бүс 2	2016 оны 6 сараас 2017 оны 5 сар	2017 оны 6 сараас 2018 оны 5 сар	2018 оны 6 сараас 2019 оны 5 сар

Хүснэгт 12: Өрхийн эдийн засгийн шинжилгээ, хамрах хугацаа

Энэхүү тайланд багтан орсон, Бүс 02-т хамаарах графикийг нь доор зураглан харуулсан (шинжилгээний хугацаа гэсэн гарчиг бүхий) шинжилгээг энэ жил (2017-2018) болон ирэх жилтэй (2018- 2019) хамааралтайгаар хийж гүйцэтгэхэд энэ талаар сайн ойлголттой байх нь чухал[16]. 2018 оны 1 дүгээр сараас хойш бараг хагас жил өнгөрөөд байна. 2017 оны сүүний үйлдвэрлэл, мал махны борлуулалт хэдийн хийгдэж, ган тохиох (2017- 2018 онд таамаглаж байсан хэмжээний хорогдол гараагүй) зэрэг олон зүйлс өрнөжээ. Цаашид тохиох гол зүйл нь энэ жилийн ноолуурын худалдаа бөгөөд энэ тохиолдолд ноолуурын үнийн таамгийг гаргах шаардлагатай.

16 Энэхүү графикийн томруулсан хувилбарыг тайлангийн төгсгөлд буй Хавсралт 1 дээр үзэж болно.

Хэрэглээний жил	Суурь он Бүс 02=2016–17												Тухайн жил=2017–18												Дараа жил=2018–19											
Саруу д	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар
Хуанлийн жил	16	16	16	16	16	16	16	17	17	17	17	17	17	17	17	17	17	17	17	18	18	18	18	18	18	18	18	18	18	18	18	19	19	19	19	19
Хур бороо	x	x	x	x									x	x	x	x									x	x	x	x								
Мал төллөлт										x	x											x	x											x	x	
Сүү үйлдвэрлэл	x	x	x	x	x								x	x	x	x	x								x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
Ноолуур борлуулалт										x	x											x	x											x	x	
Мал борлуулалт		x	x	x	x	x								x	x	x	x	x								x	x	x	x							
Хомсдол бүхий хугацаа										x	x	x										x	x	x	x									x	x	x
Шинжилгээний хугацаа																				x																

Хүснэгт 13: Судалгаанд хамрагдсан жилүүдийн улирлын хуанли (Хавсралт 1 дээр мөн оруулсан)

Ирэх жилийн хувьд (2018-19) сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, мал махны борлуулалт нь 2017-2018 оны өвлийн зудын сөрөг нөлөөнд өртөх магадлалтай. 2018-2019 оны таамгийн хувьд 2018 онд бороо хур олон жилийн дундажын орчимд байж, 2018-2019 онд зуд тохиохгүй хэмээн таамагласан.

2017–2018 оны нөхцөл байдал

Цаашид бараа бүтээгдэхүүний үнэ ямар байхыг тогтоох найдвартай аргачлал байхгүй тул тухайн жилийн болон суурь жилийн ижил саруудыг харьцуулах замаар бүс бүрт хамаарах дараах нөхцөл байдлыг таамаглан гаргасан (Хүснэгт 4). Бараа, бүтээгдэхүүний үнэнд гарах өөрчлөлтийг энэ хүснэгт дээр харуулсан (жишээ нь +15% гэдэг нь тухайн жилийг суурь жилтэй харьцуулснаас гарсан үнийн өөрчлөлт). Цэнхэр өнгөөр тэмдэглэсэн зүйлс нь судалгааны багийн мэдлэг дээр суурилан гаргасан хамгийн боломжит таамгийг харуулна. Харин хараар тэмдэглэсэн хэсэг нь албан ёсны мониторингийн мэдээллээс авсан тооцоог харуулна.

Хүснэгт 14: Үнийн нөхцөл байдал, инфляц [17]

Бүс: Аймаг →	Бүс 01: Архангай	Бүс 02: Сүхбаатар
ОРЛОГО		
Сарлаг	-17%	-
Үхэр	-	-3%
Адуу	-18%	+/- 0%
Ямаа	-12%	+5%
Хонь	-16%	+5%
Сүү/ сүүн бүтээгдэхүүн	+18%	-
Ноолуур	+/- 0%	-30%
Ноос	Инфляц	Инфляц
Арьс, шир худалдах	Инфляц	Инфляц
Мал аж ахуйн салбарт ажиллах	+/- 0%	+/- 0%
Төрийн дэмжлэг	+/- 0%	+/- 0%
ЗАРЦУУЛАЛТ		
Гурил	+16%	+4%
Будаа	+16%	+8%
Ургамлын тос	+6%	Инфляц
Элсэн чихэр	+15%	+13%
Малын эм	Инфляц	Инфляц

17 Хүснэгт дээрх хоосон нүд нь тухайн зүйл нь амьжиргааны бүсийн хувьд гол үзүүлэлт бус болохыг харуулна.

Хүснэгт 14: Үнийн нөхцөл байдал, инфляц		
Бүс: Аймаг →	**Бүс 01: Архангай**	**Бүс 02: Сүхбаатар**
	ОРЛОГО	
Мал амьтан тээвэрлэх	+29% = инфляц +20% нь зудын үеэр гарах нэмэлт зардал	+28% = инфляц +20% нь зудын үеэр гарах нэмэлт зардал
Малын тэжээл, хашаа хороо	+125% = зардал 50% нэмэгдэх, нэмэх нь худалдан авч буй хэмжээ 50% нэмэгдэх	+125% = 50% зардал 50% нэмэгдэх, нэмэх нь худалдан авч буй хэмжээ 50% нэмэгдэх
Хүн ажиллуулах (мал аж ахуйд)	+/- 0%	+/- 0%
Зээлийн төлбөр	+/- 0%	+/- 0%
Боловсрол, эрүүл мэнд	Инфляц	Инфляц
Утасны нэгж	Инфляц	Инфляц
Малын хужир давс	Инфляц	Инфляц
Инфляц	+8%	+6%

Хүснэгт 14: Үнийн нөхцөл байдал, инфляц

Албан ёсны мэдээлэл ашиглан инфляцын хувь хэмжээг тооцон (лавлагаа жилээс хойш хэд хэдэн жилийн дунджийг баримтлан) гаргасан бөгөөд өрхүүдийн амьжиргааны болон амьжиргааны баталгаажих түвшний хүнсний барааны үнийн өөрчлөлтийг тусгасан.

Малын тоо толгойн албан ёсны статистик мэдээллийг мөн ашигласан. Дараах хүснэгт дээр шинжилгээнд ашигласан мал аж ахуйн үйлдвэрлэлийг тодорхойлсныг тоймлон харуулж байна. Илүү сайн мэдээлэл цуглуулах эсвэл шийдвэр гаргагчдын зүгээс өөр нөхцөл байдлаар шийдэх тохиолдолд эдгээр таамгуудын аль нь ч өөрчлөгдөх боломжтой. Хар өнгөөр тэмдэглэсэн хэсэг нь мониторингийн мэдээлэл дээр үндэслэн хийгдсэнийг харуулна. Харин цэнхрээр харуулсан мэдээлэл нь судалгааны баг өөрийн мэдлэгт үндэслэн гаргасныг харуулна. Нэг малаас өдөрт авах сүүний хэмжээний мониторингийн мэдээлэл байхгүй гэхдээ оролцогчдын тооцож буйгаар 2017 онд зудаас үүдэн сүүний гарч 25% буурчээ. Түүнчлэн малын борлуулалт 25% буурсан нь хорио цээрийн дэглэм тогтоосноос үүдэн зах зээл хаагдсанаас болжээ.

Хүснэгт 15: Мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөхцөл байдал		
Бүс: Аймаг →	**Бүс 01: Архангай**	**Бүс 02: Сүхбаатар**
Үхэр/ сарлагийн тоо[18]	+14%	+13%
Ямааны тоо	+14%	+17%
Хонины тоо	+14%	+17%
Адууны тоо	+22%	+15%
Үхэр/ сарлагийн төллөх хувь хэмжээ	+/- 0%	+/-0%
Өдөр тутмын үхэр/сарлагийн сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	-25%	-25%
Мал зарж борлуулах зах зээлийн хүртээмж	+/- 0%	-25%
Ноолуур борлуулах[19]	-2%	+4%

18 Малын тоо толгойтой хамаарах асуудлын тодорхойлолт ньтухайн жилийн эх болон лавлагаа жилийн эхэнд буй нийт малын тоонд гарсан зөрүүг хэлэх бөгөөд үүнийг тухайн аймгийн албан ёсны мониторингийн мэдээллээс тооцон гаргадаг.

19 Энэ нь ямааны тоо толгойд гарсан өөрчлөлт бөгөөд зудаас үүдэн 10%хорогдсоныг харуулж байна.

Хүснэгт 15: Мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөхцөл байдал		
Бүс: Аймаг →	**Бүс 01: Архангай**	**Бүс 02: Сүхбаатар**
Сарлагийн хөөвөр борлуулах	+14%	
Ноос борлуулах	+19%	+18%
Арьс, шир борлуулах	+/- 0%	+/- 0%
Хувийн малын махаа хэрэглэх/ Бусдаас мах өгөх	+/- 0%	+/- 0%
Мал аж ахуйн салбарт ажил хийх	+/- 0%	+/- 0%

Хүснэгт 15: Мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөхцөл байдал

Хөдөлмөр эрхлэх болон орлогын бусад эх үүсвэрт хамаарах элементүүдийн хувьд дараах асуудлын тодорхойлолтыг ашигласан. Мөн 2017 оны зун тохиосон гангаас шалтгаалан бэлчээрийн ургамлын гарц муудна хэмээн тооцсон.

Хүснэгт 16: Хүнс, орлогын бусад эх үүсвэрийн талаарх таамаг нөхцөл байдал (тоо хэмжээний асуудал)		
Бүс: Аймаг →	**Бүс 01: Архангай**	**Бүс 02: Сүхбаатар**
Зээл	+/- 0%	+/- 0%
Төрөө олгох татаас	+/- 0%	+/- 0%
Сургуулийн хоол	+/- 0%	+/- 0%
Зэрлэг/байгалийн ургамал	-50%	-

Хүснэгт 16: Хүнс, орлогын бусад эх үүсвэрийн талаарх таамаг нөхцөл байдал (тоо хэмжээний асуудал)

2018–2019 оны нөхцөл байдал

2018 оны 6 дугаар сар болон 2019 оны 5 дугаар сарын хоорон дахь таамаг нөхцөл байдлын ихэнх нь 2017-2018 оны нөхцөлтэй ижил буй бөгөөд зөвхөн дараах өөрчлөлтүүд гарчээ:

- 2017-2018 онтой харьцуулбал малын тоо толгой, тэр дундаа үхэр, сарлагийн тоо 18%-иар, хонь, ямааны тоо толгой 15%-иар, адууны тоо толгой 5%-иар буурсан байна. Эдгээр нь 2017-2018 оны зудын үеийн хорогдлыг тооцсон дүн байна.
- Үхэр, сарлагийн төллөлтийн тоо 2017-2018 оныхтой харьцуулбал 11% доогуур байх бөгөөд энэ нь мөн л зудтай хамааралтай.
- Сүүний үйлдвэрлэл, гарцын хэмжээ нь судалгааны жилтэй ижил байна (жишээ нь 2018 оны зун ган болохгүй таамгаар).
- Мал, махны борлуулалтын хязгаарлалт 2017-2018 онд Хоёрдугаар Бүс буюу Сүхбаатар аймагт (судалгааны жилтэй харьцуулбал 25% буурсан) буурсан байгаа нь 2018-2019 онд судалгаа хийсэн хоёр бүсэд аль алинд нь буурч гарч ирж байна (энэ нь малын халдварт өвчний тархалт, хорио цээрийн дэглэмээс хамааран буурч байгаа гэсэн үг).
- Мөн 2017-2018 оны өвөл Малын тэжээл худалдан авах, тээвэрлэх нэмэлт зардал гарсан нь 2018-2019 онд дахин гарахгүй хэмээн үзсэн (зуд болохгүй).

Таамаглан гаргасан хүнсний баталгаат байдлын хэтийн төлөв

Үр дүнгийн шинжилгээнээс гарсан дүнг энэхүү хэсэгт танилцуулсан. Тухайн үр дүнд Бүлэг ДӨРӨВ дээр тусгагдсан өөрчлөлтүүд нь амьжиргааны хоёр бүсийн өөр өөр бүлгийн өрхүүдийн нийт орлогод хэрхэн нөлөөлөхийг тусган харуулсан.

2017-2018 оныг хамрах үр дүн

Дараагийн зураг дээр амьжиргааны бүсийн нэн ядуу болон чинээлэг өрхүүд дээр тодорхойлон гаргасан таамаг нөхцөл байдлыг харуулж байна. Нэн ядуу болон дундаж амьжиргаатай өрхүүдийн график мэдээлэл мөн багтсан.

АРХАНГАЙ АЙМАГ БҮС 01: 2017–2018

Тухайн хамаарах жилд (2017 оны 6 сар-2018 оны 5 сар) тулгарах асуудлуудын гол бүрэлдэхүүн хэсгийг суурь жилтэй (2015-2016) харьцуулсан нь

*Амьд малын үнэ доогуур
*Малын тоо нэмэгдсэн ч сүүний үйлдвэрлэл, гарц бага (2017 онд болсон гангаас хамаарч)
Тухайн жилд зуд тохиосонтой холбоотойгоор мал аж ахуйд зарцуулах зардал нэмэгдсэн (тэжээл, тээвэр)

- Мал, малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалт нь нэн ядуу өрхүүдийн дийлэнх хэсгийн орлогыг хангах
- Сүү үйлдвэрлэл дээр бага хэмжээний алдагдалтай, өргөн хэрэглээний хүнсний үнэ нэмэгдсэнээс үүдэн орлого бууралтаар таамагласан
- Бүх бүлэг хомсдолд өртөх магадлалгүй





Тэмдэглэгээ:
1. VP- Нэн ядуу
2. R- Чинээлэг
3. MG1- Архангай аймгийн өндөр уулын мал аж ахуйн амьжиргааны бүс
4. Хүнсний минимум хэрэгцээ 100%- Нэг хүн өдөрт 2100 Ккал

Анхаар: Үзүүлж буй зураглалууд нь нийт орлогын тооцоог (хүнс, нэмэх нь мөнгөн орлого) тухайн жил болон судалгааны жилээр харуулсан. Эдгээрийг хийгдэх үйл ажиллагаа, арга хэмжээний босготой харьцуулан (баруун талд буй) тухайн жилд хомсдол үүсэх эсэхийг тогтооно. Ягаан өнгийн хэсэг нь амьжиргааны босгыг харуулж буй бол саарал хэсэг нь амьжиргааг хамгаалах/баталгаажуулах босгыг харуулна. Хоёр график дээр хамрах хэмжээ нь ялгаатай буй.

Зураг 15: Бүс 01 Үр дүнгийн шинжилгээ, 2017–18

СҮХБААТАР АЙМАГ БҮС 02: 2017–2018

Тухайн хамаарах жилд (2017 оны 6 сар-2018 оны 5 сар) тулгарах асуудлуудын гол бүрэлдэхүүн хэсгийг суурь жилтэй (2016-2017) харьцуулсан нь

* Амьд малын үнэ тогтвортой Малын тоо нэмэгдсэн ч сүүний үйлдвэрлэл, гарц бага (2017 онд болсон гангаас үүдэн)
* Тухайн жил зуд тохиосонтой холбоотойгоор мал аж ахуйд зарцуулах зардал нэмэгдсэн (тэжээл, тээвэр)
* Хорио цээрийн дэглэмээс үүдэн малын худалдаа хязгаарласан

- Мал, малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалт нь ядуу өрхүүдийн орлогын хагасыг бүрдүүлэх
- Сүү үйлдвэрлэл дээр бага хэмжээний алдагдалтай, малын худалдаа буурснаас үүдэн орлого буурахаар таамагласан
- Нэн ядуу өрхүүд нь амьжиргаа хамгаалах шаардлагатай бага хэмжээний хомсдолд өртөх магадлалтай





Тэмдэглэгээ:
1. VP-Нэн ядуу
2. R-Чинээлэг
3. MG 2-Сүхбаатар аймгийн тал хээрийн бүсийн мал аж ахуйн амьжиргааны бүс
4. Хүнсний минимум хэрэгцээ 100%-Нэг хүн өдөрт 2100 Ккал

Зураг 16: Бүс 02 Үр дүнгийн шинжилгээ, 2017–2018

Нэгтгэн авч үзвэл нэгдүгээр бүсийн буюу Архангай аймгийн өрхүүд нь 2017-2018 онд амьжиргаа баталгаажуулах арга хэмжээ авах шаардлага эсвэл амьжиргааны хомсдолтой нүүр тулахгүй болохыг дээрх таамагт үндэслэн тогтоож байна. Хоёрдугаар бүс буюу Сүхбаатар аймгийн нэн ядуу өрхүүд нь амьжиргааны баталгаажих түвшний шугам дээр байна (босгоос арай доогуур). Энэ нь малын борлуулалтад маш мэдрэг бөгөөд малын худалдааны бууралтаас ихээхэн хамаардаг (2017 онд тавигдсан хорио цээрийн улмаас), 2018 оны ноолуурын таамагласан үнээс мөн хамааралтай байна. Үүнийг харгалзан үзвэл Сүхбаатар аймгийн энэхүү амьжиргааны баталгаажих түвшинд хүрэхгүй байгаа бүлэгт зарим төрлийн тусламж дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа байж болно.

Эргэн сануулахад амьжиргааг хамгаалах/баталгаажих хомсдол гэдэг нь тухайн өрхүүд судалгааны жилд өөрсдөө мөнгө зарцуулан худалдан авах боломжтой олон тооны нэн тэргүүн хэрэгцээт зүйлсийг, жишээ нь боловсрол, эрүүл мэнд, хувцас, хүнсний болон бусад шаардлагатай зүйлсийг худалдан авах боломжгүй нөхцөлд орохыг хэлнэ. Энэхүү нөхцөл байдалтай нүүр тулгарсан өрхүүд нь амьжиргааны баталгаажих түвшнээс доор орж зарим шаардлагатай зүйлсийг худалдан авах сонголт хийж, улмаар өлөн зэлмүүн байхч үе гардаг байна.

2018-2019 оныг хамрах үр дүн

2018-2019 онд тохиож болзошгүй хэмээн дээр тодорхойлон гаргасан өөрчлөлтүүд нь 2017-2018 онтой харьцуулбал хүндрэл багатай гэхдээ 2017-2018 оны өвөл малын хорогдол нэмэгдэх хүндрэл үүсэхээр байна.

Дараагийн зураг дээрамьжиргааны бүс/аймгийн нэн ядуу болон чинээлэг амьжиргаа бүхий өрхүүд дээр тодорхойлон гаргасан нөхцөл байдлыг харуулж байна. Нэн ядуу болон дундаж түвшний амьжиргаатай өрхүүдийн график мэдээлэл мөн багтсан.

АРХАНГАЙ АЙМАГ БҮС 01: 2018–2019

Тухайн онд (2018 оны 6 сар-2019 оны 5 сар) тулгарах асуудлуудын гол бүрэлдэхүүн хэсгийг суурь жилтэй (2017-2018) харьцуулсан нь

* Үнийн хувьд тогтвортой
* Зуднаар мад ихээр хорогдсонтой холбоотойгоор малын тоо буурсан
* Мал хээл хаяснаас үүдэн шинэ төлийн тоо цөөн
*Малын өвчнөөс үүдэн малын худалдаа хязгаарласан

Тэжээл, тээвэр зэрэг нэмэлт зардал гаргах боломжгүй

- Мал, малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалт нь нэн ядуу өрхүүдийн орлогын хагасыг бүрдүүлэх
- Сүү үйлдвэрлэл дээр бага хэмжээний алдагдалтай, малын худалдаа буурснаас үүдэн дараа жил орлого буурахаар таамагласан
- Бүх бүлэг амьжиргаа хамгаалах шаардлагатай босгод хүрэх эсвэл ойртох магадлалгүй





Тэмдэглэгээ:
1. VP-Нэн ядуу
2. R-Чинээлэг
3. MG1- Архангай аймгийн өндөр уулын мал аж ахуйн амьжиргааны бүс
4. Хүнсний минимум хэрэгцээ 100%- Нэг хүн өдөрт 2100 Ккал

Зураг 17: Бүс 01 2018–2019 оны Үр дүнгийн шинжилгээ

СҮХБААТАР АЙМАГ БҮС 02: 2018–2019

Тухайн онд (2018 оны 6 сар-2019 оны 5 сар) тулгарах асуудлуудын гол бүрэлдэхүүн хэсгийг суурь жилтэй (2017-2018) харьцуулсан нь

* Үнийн хувьд тогтвортой
* Зуднаар мад ихээр хорогдсонтой холбоотойгоор малын тоо буурсан
* Мал хээл хаяснаас үүдэн шинэ төлийн тоо цөөн

*Малын өвчнөөс үүдэн малын худалдаа хязгаарласан

Тэжээл, тээвэр зэрэг нэмэлт зардал гаргах боломжгүй

- Мал, малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалт нь нэн ядуу өрхүүдийн орлогын хагасыг бүрдүүлэх
- Сүү үйлдвэрлэл дээр бага хэмжээний алдагдалтай, малын худалдаа буурснаас үүдэн дараа жил орлого буурахаар таамагласан
- Бүх бүлэг амьжиргаа хамгаалах шаардлагатай босгод хүрэх эсвэл ойртох магадлалгүй





Тэмдэглэгээ:

1. VP-Нэн ядуу
2. R-Чинээлэг
3. MG1-Сүхбаатар аймгийн тал хээрийн бүсийн мал аж ахуйн амьжиргааны бүс
4. Хүнсний минимум хэрэгцээ 100%-Нэг хүн өдөрт 2100 Ккал

Зураг 18: Бүс 02 2018–2019 оны Үр дүнгийн шинжилгээ

Нэгтгэн дүгнэн үзвэл судалгааны хүрээнд дэвшүүлсэн таамаг нь тухайн хоёр амьжиргааны бүсийн өрхүүдийн хувьд 2018-2019 онуудад нь амьжиргаа хамгаалах арга хэмжээ эсвэл амьжиргааны хомсдолтой нүүр тулах магадлалгүйг харуулж байна. Харин 2017-2018 оныг хамарсан шинжилгээний үр дүн амьд малын худалдаанд гарах бууралт (хорио цээрийн дэглэмээс шалтгаалан), ноолуурын үнийн таамгаас үзвэл нэлээд эмзэг байж болох дүр зураг харагдаж байна. 2018-2019 оныг хамруулан хийсэн таамгийн дагуу тухайн бүсүүдийн нэн ядуу өрхүүд амьжиргаа хамгаалах/тэтгэх босгонд маш ойр хэмжээнд байх бөгөөд тэдний нөхцөл байдалд байнга мониторинг хийж байх шаардлагатай. Нэмэлт мэдээлэл цуглуулсан тохиолдолд шинжилгээнд ашигласан аль ч таамгийг эргэн харах боломжтой.

Хавсралт 1: Улирлын хуанли

Хэрэглээний жил	Суурь он Бүс 02=2016-17												Тухайн жил=2017-18												Дараа жил=2018-19											
Саруд	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар
Хуанлийн жил	16	16	16	16	16	16	16	17	17	17	17	17	17	17	17	17	17	17	17	18	18	18	18	18	18	18	18	18	18	18	18	19	19	19	19	19
Хур бороо	x	x	x	x									x	x	x	x									x	x	x	x								
Мал төллөлт										x	x											x	x											x	x	
Сүү үйлдвэрлэл	x	x	x	x	x								x	x	x	x	x								x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
Ноолуур борлуулалт										x	x											x	x											x	x	
Мал борлуулалт		x	x	x	x	x								x	x	x	x	x								x	x	x	x	x						
Хомсдол бүхий хугацаа										x	x	x										x	x	x	x									x	x	x
Шинжилгээний хугацаа																				x																